

БАНКНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ -
ХУВЬ ХҮН

2023.06.22

ГАРЧИГ

| | |
|--|----|
| НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ | 3 |
| ХОЁР. ХАРИЛЦАХ ДАНС | 3 |
| ГУРАВ. ТӨЛБӨРИЙН ДЕБИТ КАРТ | 4 |
| ДӨРӨВ. ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 7 |
| ТАВ. МОСТ МОНИ ҮЙЛЧИЛГЭЭ | 10 |
| ЗУРГАА. ХУРИМТЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 11 |
| ДОЛОО. АВТОМАТ БИЛЛ ҮЙЛЧИЛГЭЭ | 12 |
| НАЙМ. МЭДЭГДЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 13 |
| ЕС. БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН | 14 |

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Энэхүү Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл нь (цаашид “БҮЕН” гэх) Харилцагчийн банктай байгуулсан Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)ний гэрээний салшгүй хэсэг болно. Харилцагч нь энэхүү БҮЕН-ийг зөвшөөрөхгүй тохиолдолд Гэрээнд заасан хугацаа буюу нийтэд мэдээлсэн өдрөөс ажлын 10 хоногийн дотор Банканд (данс нээлгэсэн салбар, тооцооны төвд) бичгээр мэдэгдэх эрхтэй ба мэдэгдээгүй тохиолдолд БҮЕН-ийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

1.2. Карт, пин код, гар утас, нэвтрэх болон гүйлгээний нууц үг болон бусад баталгаажуулалтын хэлбэрийг алдсан, бусдад задруулсан гэж үзэж байгаа болон нууцлалын төхөөрөмжийг гээсэн, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд бүтээгдэхүүн үйлчилгээний төрлөөс хамааран дараах сувгаар Банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах үүрэгтэй. Үүнд:

| | 1900-1977, 1800-1977 дугаарт холбогдох (гадаадаас 976- 70161988) | info@tdbm.mn-д банканд бүртгэлтэй өөрийн цахим хаягаас хандах | Банкны салбар, тооцооны төв дээр биечлэн ирэх | ТиДиБи Онлайн үйлчилгээгээр дамжуулах | Мост мони үйлчилгээгээр дамжуулах |
|-------------------------|--|---|--|--|---|
| Карт | √ | √ | √ | √ | |
| Мост Мони | √ | √ | √ | | √ |
| ТиДиБи Онлайн | √ | √ | √ | | |
| Мэдэгдлийн үйлчилгээ | √ | √ | √ | | |

1.3. Гүйлгээнд тавих банкны хязгаарлалт

1.3.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хийгдэх гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах үүднээс Банк гүйлгээ гаргах боломжит хэмжээг “Харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ”-ний 2.2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааруулж дараах байдлаар ялгаатай тогтооно. Үүнд:

| | Нэг удаа хийх гүйлгээний дүнгийн дээд хэмжээ | Өдөрт хийх гүйлгээний дүнгийн дээд хэмжээ | Нууц үг, пин код оруулах оролдлогын тоо |
|---|--|---|---|
| Карт /Үйлчилгээний байгууллага, АТМ, банк болон бусад банкны харъяа салбар, тооцооны төв/ | Картын төрлөөс хамаарна | Картын төрлөөс хамаарна | Картын төрлөөс хамаарна |
| Мост Мони /бэлэн, бэлэн бус гүйлгээ/ | 2,000,000₮ | Үйлчилгээний төрлөөс хамаарна | Үйлчилгээний төрлөөс хамаарна |
| ТиДиБи Онлайн | Багцын төрлөөс хамаарна | Багцын төрлөөс хамаарна | Багцын төрлөөс хамаарна |

ХОЁР. ХАРИЛЦАХ ДАНС

2.1. Харилцах дансыг ХШЕН-д заасан валютын сонголттой нээж, дансаараа дамжуулан банкны төлбөр тооцооны үйлчилгээг авах боломжтой.

2.2. Харилцагч нь харилцах данстай холбоотой бүх төрлийн үйлчилгээг салбар, тооцооны төв харгалзахгүй авна.

2.3. Банк харилцах данстай холбоотой дараах тусгай үүрэгтэй:

2.3.1. Банк хоорондын гүйлгээ илгээх сүлжээний сүүлчийн цагаас хойш хийгдсэн гүйлгээ дараагийн ажлын өдөрт багтаан орох;

2.4. Банк харилцах данстай холбоотой дараах тусгай эрхтэй:

2.4.1. Дансанд өөр төрлийн валютаар шилжиж ирсэн гуйвуулгыг банкнаас зарласан тухайн өдрийн арилжааны ханшаар хөрвүүлж гүйлгээг хийх;

2.4.2. Данс, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах зорилгоор харилцагчаас бусад мэдээллийн талаар тодруулж шалгах, баталгаажуулах;

2.4.3. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн дагуу сэжигтэй гэж үзсэн гүйлгээг шалгах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлэх

2.4.4. Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага, хуульд заасан бусад эрх бүхий байгууллагын мэдэгдлийн дагуу, мөн зээл, хүүгийн төлбөрийг харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгах;

2.4.5. Харилцагч дансаар хоёр жил ба түүнээс дээш хугацаанд гүйлгээ хийгээгүйн улмаас данс идэвхгүй төлөвт шилжиж, данс тэг үлдэгдэлтэй болсон тохиолдолд банк дансыг хаах;

2.5. Харилцагч харилцах данстай холбоотой дараах тусгай үүрэгтэй:

2.5.1. Дансанд заавал байлгах үлдэгдлийг данс нээсэн тухайн өдөрт байршуулах;

2.5.2. Төлбөр тооцооны болон бусад баримт бичгийг үнэн зөв мэдүүлж, банкны үйлчилгээг авах;

2.5.3. Дансыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглахгүй байх;

2.5.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж хийсэн гүйлгээнд тогтмол хяналт тавьж байх, төлбөр тооцооны үүрэг хариуцлагыг нь хүлээх;

2.5.5. Данснаасаа 50,000.00 ам.доллар, 50,000,000.00 төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг бэлнээр авах тохиолдолд ажлын 1 хоногийн өмнө банканд мэдэгдэнэ. Харилцагч нь бэлнээр авах гүйлгээний дүнг заавал өөрийн дансанд байршуулсны дараагаар банканд хандан, урьдчилан захиалга үүсгүүлэх боломжтой.

2.6. Харилцагч харилцах данстай холбоотой дараах тусгай эрхтэй:

2.6.1. Тогтоосон журмын дагуу банканд данс нээлгэн үйлчлүүлэх, төлбөр тооцооны үйлчилгээ авах;

2.6.2. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, үйлчилгээний хүү, шимтгэлийн талаар санал хүсэлт гаргах;

2.6.3. Данс, гүйлгээ, төлбөр тооцооны талаарх мэдээллийг банкаар гаргуулан авах;

2.6.4. Банктай байгуулсан гэрээг хугацаанаас өмнө цуцалж, өөрийн хүсэлтээр дансаа хаах.

ГУРАВ. ТӨЛБӨРИЙН ДЕБИТ КАРТ

3.1. Төлбөрийн дебит карт нь олон улсын болон дотоодын төлбөр тооцооны шаардлага стандартыг хангасан нууцлал бүхий бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо хийхэд зориулан Харилцагчид олгосон карт байна.

3.2. Харилцагч нь төлбөрийн дебит картаа ашиглан карт төлбөрт хүлээж авах эрхтэй үйлчилгээний байгууллагуудад худалдаа, үйлчилгээний төлбөрийг төлөх, АТМ (Автомат теллер машин) болон Банкны зүгээс үзүүлж буй бусад гүйлгээ хийх, нэмэлт үйлчилгээг авах боломжтой байна.

3.3. Карт нь Банкны өмч байх бөгөөд харилцагчийн Банкн дахь дансуудтай холбогдсон, уг дансуудыг төлөөлсөн төлбөрийн хэрэгсэл болно.

3.4. Банк төлбөрийн дебит карттай холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

3.4.1. Харилцагч картаараа худалдан авсан бараа, үйлчилгээний нийт дүнд ногдох урамшуулал, эсхүл урамшууллын оноог картын төрлөөс хамааруулан харилцагчийн холбогдох дансанд бэлэн бусаар шилжүүлж байх (энэ заалт тухайн төрлийн карт урамшуулалтай тохиолдолд хамаарна);

3.4.2. Харилцагч төлбөр төлсөн бараа, үйлчилгээгээ буцаасан эсвэл илүү дүнгээр гүйлгээ хийсэн бол холбогдох дүнг Картаар үйлчлэгч байгууллага (цаашид “КҮБ” гэх)-ын бичгээр гаргасан зөвшөөрлийг үндэслэн харилцагчийн дансанд, урамшууллын дүнг КҮБ-ын дансанд буцааж шилжүүлэх;

3.4.3. Шуудангаар дамжуулан карт хүлээн авах хүсэлт гаргасан харилцагчийн заасан хаягт шуудангаар хүргүүлэх үүрэгтэй.

3.5. Банк төлбөрийн дебит карттай холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

3.5.1. Харилцагчийн дансаар луйврын шинжтэй байж болзошгүй гүйлгээ гарсан тохиолдолд харилцагчийн Банканд бүртгүүлсэн утасны дугаар, цахим шуудангийн хаягаар холбогдож гүйлгээг баталгаажуулах, холбогдож чадаагүй тохиолдолд картыг түр хугацаанд хаах;

3.5.2. Харилцагч захиалсан картаа 6 сарын дотор Банкнаас ирж аваагүй бол картыг хүчингүй болгох;

3.5.3. АТМ-д хураагдсан картыг хураагдсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд Банкнаас аваагүй бол картыг хүчингүй болгох;

3.5.4. Харилцагчийн худалдан авсан бараа үйлчилгээний төлбөр дутуу, буруу суутгагдсан талаар КҮБ-аас хүсэлт гаргасан тохиолдолд холбогдох баримтыг харилцагчид танилцуулсны үндсэн дээр зөрүү дүнг картын данснаас нь суутгах, харилцагчтай холбогдож чадаагүй бол тухайн дүнгээр дансанд хаалт тавих;

3.5.5. Харилцагч фото карт дээр хэвлэхийг хориглосон утга, агуулга бүхий зураг, лого зэргийг карт дээр хэвлүүлэхээр хүсэлт гаргасан тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах.

3.5.6. Харилцагчид картыг шуудангаар хүргэх үйлчилгээний хүргэлтийн хугацааны дээд хязгаар 14 хоног байх бөгөөд хэрэв харилцагч хүсэлтэд заасан хаягт эзгүй байх тохиолдолд шуудангийн хүргэлтийг зогсоох эрхтэй.

3.5.7. Банк гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд хуанлийн 30 (гуч) хоногийн өмнө Банкны цахим сувгуудаар дамжуулан харилцагчид мэдэгдсэнээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Заасан хугацаанд харилцагч гэрээнээс татгалзаагүй бол гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

3.6. Харилцагч төлбөрийн дебит карттай холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

3.6.1. Олон улсын төлбөрийн картын хувьд, харилцагч интернет худалдан авалтад зориулсан интернет пин кодыг Банкны салбар, АТМ болон банкны лавлах төв (1900-1977, 1800-1977, гадаадаас 976-70161988), эсхүл ТиДиБи Онлайн үйлчилгээг ашиглан авна. Дотоодын “F” картын хувьд дотоодын интернет худалдан авалтад зориулсан интернет пин код нь картын пин кодтой ижил байх бөгөөд интернет худалдан авалт хийхдээ пин кодыг оруулаагүй хийсэн гүйлгээний аливаа эрсдэл, хохирол зардлыг бүрэн хариуцах;

3.6.2. Банкнаас картаа солиулах тухай мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд картаа Банканд хандан солиулах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

3.6.3. Гадаад, дотоодын бусад банкны сүлжээнд картаар хийгдсэн гүйлгээнээс үүдсэн нэмэлт хүү, шимтгэл, ханшийн зөрүүг бүрэн хариуцах;

3.6.4. Харилцагч нь КҮБ-ын карт уншигч төхөөрөмжинд картаа уншуулж төлбөр тооцоо гүйцэтгэхдээ КҮБ-ын ажилтанд картаа өгч явуулахгүй байх, картын пин код болон бусад мэдээллийг КҮБ-ын ажилтанд мэдэгдэхгүй байх, картыг өөрийн хараа, хяналтын дор уншуулж, хяналт тавьж байх;

3.6.5. Харилцагчийн фото картад хэвлүүлсэн зураг болон лого нь гуравдагч этгээдийн эрх ашигт нийцэхгүй, зохиогчийн эрх, патент, хувийн нууцтай холбоотой байснаас гарсан гомдол, хохирлыг хариуцна;

- 3.6.6. Фото карт дээр хэвлэгдэх зургийн чанар (харагдах байдал), дизайныг харилцагч өөрөө хариуцах бөгөөд зургийн чанар, дизайнаас шалтгаалан карт дээрх зураг шаардлага хангаагүй (бүдэг гарсан) тохиолдолд хэвлэгдсэн фото картын үнийг Банк харилцагчид буцаан олгохгүй;
- 3.6.7. Харилцагч ТиДиБи Онлайн үйлчилгээгээр дамжуулан картаа захиалсан бөгөөд уг картыг гуравдагч этгээдэд хүлээлгэн өгөхийг хүсвэл карт захиалах хүсэлтдээ картыг хүлээн авах гуравдагч этгээдийн мэдээллийг тусгах бөгөөд гуравдагч этгээд картыг хүлээн авахдаа өөрийн иргэний хүчин төгөлдөр баримт бичигтэйгээр Банкны салбар, тооцооны төвд биечлэн ирнэ;
- 3.6.8. Харилцагч өөрийн хүсэлтээр картын өдөрт зарцуулах лимитийг өөрчлүүлснээс үүдэн гарах аливаа хохирол, эрсдэлийг бүрэн хариуцна;
- 3.6.9. Харилцагч нь картаа хаалгаснаас хойш тус картаар өмнө нь хийсэн аливаа гүйлгээний нэхэмжлэл, авлага ирвэл харилцагч өөрөө хариуцна;
- 3.6.10. Харилцагч нь захиалсан картаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр эсхүл карт захиалах үедээ бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн, хүсэлтэд заасан этгээдээр дамжуулан авч байгаа бол картаа авсныхаа дараа Банканд бүртгэлтэй утаснаас банкны 133133 дугаарт мессэжээр, эсхүл Банканд бүртгэлтэй цахим хаягнаас info@tdbm.mn хаягт хүсэлт гарган холбогдож идэвхжүүлнэ.
- 3.6.11. Харилцагч картаа шуудангаар хүлээн авах хүсэлт гаргахдаа картаа хүлээн авах, холбогдох мэдээллийг хүсэлтэд үнэн зөв, бодитой мэдээлж бичих үүрэгтэй;
- 3.6.12. Харилцагч шуудангаар хүлээн авсан картын дугтуйны бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авах үүрэгтэй.

3.7. Харилцагч төлбөрийн дебит карттай холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 3.7.1. Банкны салбар, тооцооны төвд хандан дансандаа хамтран эзэмшигч, дэд карт эзэмшигчийг нэмэх болон карт дахин хэвлүүлэх, картын төлөв өөрчлөх, пин код шинэчилж авах, өдөрт зарцуулах гүйлгээний лимитийг өөрчлүүлэх;
- 3.7.2. Урамшуулалт карт эзэмшигч нь Банктай гэрээ бүхий КҮБ-д оноог зарцуулж ашиглах;
- 3.7.3. Гүйлгээнд тавих Банкны хязгаарлалтыг өөрчлүүлэх тухай хүсэлтээ өөрийн ТиДиБи Онлайн үйлчилгээгээр, утсаар болон цахим шуудангийн хаягаар гаргах эрхтэй ба гүйлгээний түүх болон бусад мэдээллийг үндэслэн түр хугацаагаар өөрчлөх эсэх талаар Банк шийдвэр гаргах;

3.8. Төлбөрийн дебит карттай холбоотой нэмэлт хариуцлага

- 3.8.1. Харилцагч өөрийн карт болоод нэмэлт картаар хийсэн /хийгдсэн, хийх/ төлбөр тооцоо, үйлчилгээний хураамж, шимтгэлийг Банк болон КҮБ, бусад харилцагч байгууллага, банкуудын өмнө бүрэн хариуцна.
- 3.8.2. Харилцагч өөрийн картын найдвартай байнгын ажиллагааны дагуу картын ар талд баталгаат гарын үсгийг зурж, картын хүчинтэй хугацааны дуусах хугацааг анхаарч үйлчлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Банканд тухай бүр нь мэдэгдэж картаа шалгуулах, картын хугацааг сунгуулах, дахин хэвлүүлэх, пин кодыг шинээр авах үүрэгтэй ба шалгаагүй, Банканд мэдэгдээгүйгээс болж өөрт учирсан аливаа хохирол, маргаантай асуудлыг харилцагч өөрөө хариуцах ба Банк хариуцахгүй.
- 3.8.3. Виза, ЮнионПей картын сүлжээнд харилцагчийн хийсэн гүйлгээ тухайн валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болох ханшийн зөрүү болон Виза, ЮнионПей интернэйшнлээс ХШЕН-өөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг Харилцагч бүрэн хариуцна.
- 3.8.4. Банкны сүлжээнээс гадна буюу Виза, ЮнионПей картын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн харилцагчийн гүйлгээнд тэдгээрээс нэмж тооцсон /тооцох/ төлбөр, хураамж, шимтгэлийг тухайн бүс нутаг, улсын банкны болоод санхүү, бизнесийн байгууллагын дотоод журам, зохицуулалтын дагуу тооцогдох тул үүнийг Банк хариуцахгүй.
- 3.8.5. Картын дансны валютаас өөр төрлийн валютаар төлбөр тооцоо хийсэн тохиолдолд гүйлгээний ханш нь Виза Интернэйшнл, ЮнионПэй Интернэйшнл байгууллагуудын тухайн өдрийн ханш болон төлбөр

тооцоог хүлээн авагч банкны ханшаар тооцогдоно. Картын дансанд гүйлгээний тусах ханш нь нэхэмжлэгч талаас нэхэмжлэл ирүүлэн зарлага гарах өдрийн ханшаар тооцогдоно.

3.8.6 Харилцагч нь олон улсын болон дотоодын цахим худалдааны вэбсайтаас онлайнаар бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар бүртгүүлсэн бол тухайн төлбөр нь тогтмол давтамжтайгаар төлбөр суутгагддаг эсэх болон бусад төлбөрийн нөхцөлүүдтэй сайтар танилцан гүйлгээ хийнэ. Тухайн вэбсайтаас тогтмол үйлчилгээг авах шаардлагагүй болсон үедээ картын бүртгэлээ цуцлаагүйн улмаас үүдэх төлбөрийг харилцагч хариуцна.

3.8.7. Харилцагч энэхүү гэрээний 3.6.7, 3.6.10.-д заасны дагуу гуравдагч этгээдэд захиалсан картаа олгох талаар хүсэлт гаргасан тохиолдолд карт, картын гүйлгээтэй холбоотой гарах аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.

3.8.8. Харилцагч шуудангаар картаа хүргүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хүргэлтийн хугацааны дээд хязгаар 14 хоног байх бөгөөд хэрэв харилцагч хүсэлтэд заасан хаяг, хугацаанд эзгүй байх тохиолдолд шуудангийн хүргэлтийг зогсоож, картыг банкуу эргүүлэн татаж харилцагч анх карт захиалсан салбараас картаа ирж авах ба шуудангаар карт хүлээн авах хаяг, холбогдох мэдээллийг алдаатай буруу мэдээлж бичсэнээс болж карт хугацаандаа очихгүй байх болон учирсан хохирол зардлыг Банк хариуцахгүй

ДӨРӨВ. ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээний эрхээрээ интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан, www.etdbm.mn цахим хуудсаар болон Ти Ди Би Онлайн аппликейшнээр дамжуулан Банкны үйлчилгээг авах боломжтой.

4.2. Харилцагч нь ТИ ДИ БИ Онлайн үйлчилгээг ашиглан, өөрийн сонгосон багцаас хамааран Банкны үйлчилгээний мэдээлэл авах, бэлэн бус гүйлгээ хийх, зээл, хадгаламжийн хүсэлт илгээх, карт захиалах, Мост Мони үйлчилгээнд бүртгүүлэх хүсэлт илгээх, арилжааны хэлцэл хийх, мэдэгдлийн үйлчилгээ үйлчилгээний хүсэлт илгээх, хадгаламж барьцаалсан зээл авах, хаах үйлчилгээг боломжтой байна.

4.3. Банк нь Ти Ди Би Онлайн үйлчилгээнд нэвтрэх харилцагчийг таних, гүйлгээний зөвшөөрлийг батлах, Харилцагч болон Банкныг эрсдэлээс хамгаалах зорилгоор нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг гэсэн нууцлалын элементүүдийг хослуулан багц бүрт ялгаатайгаар ашиглуулна. Үүнд:

| Д/д | Багцын нэр | Нууцлалын элементүүд | | | |
|-----|--------------------------|----------------------|-----------------|--------------------------|--------------------|
| | | Нэвтрэх нэр | Нэвтрэх нууц үг | Нэг удаагийн нууц дугаар | Гүйлгээний нууц үг |
| 1. | Онлайн | √ | √ | | √ |
| 2 | Онлайн инфо-хувь хүн | √ | √ | | |
| 3 | Онлайн плас | √ | √ | √ | √ |
| 4 | Онлайн премиум | √ | √ | √ | √ |
| 5 | Онлайн премиум хэлцэлтэй | √ | √ | √ | √ |
| 6 | Бусад | √ | √ | √ | √ |
| 7 | Онлайн - Кидс | √ | √ | | |
| 8 | Онлайн – Жүниор | √ | √ | | |

4.4. Харилцагч 24 цагийн туршид (төлөвлөгөөт засвар үйлчилгээний цагт үйлчлэхгүй) Ти Ди Би Онлайн үйлчилгээг хүлээн авах боломжтой.

4.5. Банкнаас харилцагчид худалдсан нууцлалын төхөөрөмжийн баталгаат хугацаа нь харилцагчтай төхөөрөмж хүлээлцэх акт үйлдсэн өдрөөс хойш 1 жил байна

4.6. Банк Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

4.6.1. Харилцагчийн илгээсэн хүсэлтийн дагуу картын төлөв солих, лимит өсгөх, үндсэн данс солих, данс холбох, салгах, карт шинээр буюу дахин захиалах үйлчилгээг үзүүлэх;

4.6.2. Харилцагчийн илгээсэн зээлийн хүсэлтийг судалж олгох шийдвэр гарсан тохиолдолд харилцагчтай холбогдох гэрээ, хэлцлийг цахимаар эсвэл бичгээр байгуулна;

4.6.3. Харилцагчийн хүсэлтээр харилцах, хадгаламжийн данс нээж, харилцагчтай цахимаар эсхүл бигчгээр гэрээ байгуулсны үндсэн дээр зарлагын гүйлгээ гаргах эрх нээгдэх;

4.6.4. Тухайн ажлын өдрийн тасалбар болгох хугацаанд оруулсан гүйлгээ нь тухайн ажлын өдөрт хийгдсэнд тооцох бөгөөд бусад хугацаанд хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөрт хийгдэнэ. Энэ хугацаанд хүлээлгэд байна.

| Д/д | Гүйлгээний төрөл | Тасалбар болгох хугацаа (Улаанбаатар хотын цагаар) |
|-----|---|---|
| 1 | Өөрийн данс хооронд | Тухайн өдрийн банкны тасалбар болгох хугацаанаас дараа өдрийн тасалбар болгох хугацаа хүртэл* |
| 2 | Банк доторх | |
| 3 | Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан "бага дүнтэй гүйлгээ" | Ажлын өдрийн 09:00 – 15:30 хооронд |
| 4 | Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан "их дүнтэй гүйлгээ" | |

*Банкны тасалбар болгох хугацаа нь 00:00 цагаас 04.00 цагийн хооронд байна.

4.6.5. Тухайн шилжүүлэх дансны цахим төлбөрийн даалгаврын өгөгдлийг бүрэн шивсэн, данс дахь үлдэгдэл нь тухайн дүн болон холбогдох шимтгэлийг төлөхөд хүрэлцэж байгаа тохиолдолд гүйлгээ хийгдэнэ.

4.7. Банк Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

4.7.1. Харилцагч үйлчилгээ ашиглах явцад 5ын дотор функцын үйлдэл хийгээгүй тохиолдолд харилцагч болон Банкны эрсдэлээс хамгаалах зорилгоор тухайн программаас автоматаар гаргах;

4.7.2. Харилцагч болон банкны эрсдэлээс хамгаалан, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц үгийн аль нэгийг нь 5 удаа буруу оруулсан тохиолдолд Харилцагчийн тухайн нууц үгийг системээс автоматаар блоклох;

4.7.3. Банкны эрсдэлээс бодлогын дагуу болон бусад олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргийн дагуу сэжигтэй гүйлгээг зогсоох;

4.7.4. Эрсдэлээс сэргийлэх олон улсын дүрэм, журмын дагуу нууцлал, хамгаалалтын стандарт нэмж тогтоох, өөрчлөх;

4.7.5. Үйлчилгээгээр ирүүлсэн хүсэлтийн талаар харилцагч талаас ямар нэгэн хариу ирүүлэлгүй хуанлийн 30-аас дээш хоног өнгөрсөн тохиолдолд Банк хүсэлтийг цуцалж, хаана.

4.7.6. Банк харилцагчийн идэвхгүй байдлыг үндэслэн 1 жилээс дээш хугацаанд идэвхгүй байсан тохиолдолд харилцагчийн Ти Ди Би Онлайн үйлчилгээний бүртгэл болон эрхийн зүйлийн төлөвийг өөрчлөх.

4.8. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

4.8.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан Банканд илгээх хүсэлтийг үнэн зөв бөглөж өгөх;

4.8.2. Банкнаас үүсгэж өгсөн ТиДиБи Онлайн үйлчилгээний нэвтрэх болон гүйлгээний нууц үгийг тухай бүр өөрчилж байх;

- 4.8.3. Банк харилцагчийн нэвтрэх нэр, нууц үгсийн талаарх мэдээллийг харилцагчаас авахаар шаардахгүй тул Банктай ижил нэр, цахим хаягнаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх үүрэгтэй ба үүнээс үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцах. Ийм хүсэлт ирсэн тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэх;
- 4.8.4. Нэвтрэх болон гүйлгээний нууц үгээ хамгийн багадаа 6-н сар тутам сольж хэвших;
- 4.8.5. Гуравдагч этгээдэд Ти Ди Би Онлайн үйлчилгээнд нэвтрэн дансаа захиран зарцуулах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн тохиолдолд Банканд энэ тухай хандаж, албан ёсны итгэмжлэлээр шилжүүлэх;
- 4.8.6. Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглаж дууссан даруйдаа программаас бүрэн гарч байх, энэ үүргийг дагаагүйгээс болж үүдэн гарах хохирлыг хариуцах;
- 4.8.7. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд ашиглаж буй компьютерийн болон гар утасны интернэтийн төлбөрийг хариуцах;
- 4.8.8. Нууцлалын төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах.
- 4.8.9. Гэрээнд хэрхэн зааснаас үл хамааран Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан Харилцагч өөрийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нууц үгийг ашиглан Банкнаас санал болгож буй БҮЕН-д нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний төслийг хүлээн зөвшөөрсөн үйлдэл хийснээр тухайн БҮЕН-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг бичгээр байгуулж, гарын үсэг зурсантай ижил хүчин төгөлдөр гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

4.9. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээний багцаас хамаарч дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 4.9.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан өөрийн данс хооронд, Банкны салбар, тооцооны төв хооронд, банк хооронд, гадаад шилжүүлэг, багц гүйлгээ, тогтмол хуримтлалын гүйлгээ, цалингийн багц гүйлгээ, арилжааны хэлцэл зэрэг бэлэн бус гүйлгээ хийх;
- 4.9.2. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан картын төлөв солих, картын лимит өсгөх, картын үндсэн данс солих, картын данс холбох, салгах, карт дахин захиалах, карт шинээр захиалах;
- 4.9.3. Зээлийн хүсэлт илгээж, шийдвэрлүүлэх;
- 4.9.4. Данс нээх, хадгаламжийн хугацаа сунгах;
- 4.9.5. Мост Мони үйлчилгээнд шинээр бүртгүүлэх, Мост Мони үйлчилгээний үндсэн данс солих;
- 4.9.6. Мэдэгдлийн үйлчилгээний хүсэлт илгээх;
- 4.9.7. Ти Ди Би Онлайн үйлчилгээний багц ахиулах хүсэлт илгээх;
- 4.9.8. Бичгээр гаргасан хүсэлтээр үйлчилгээний эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах (Энэ тохиолдолд өмнө нь төлсөн хураамжийг Банк буцаан олгохгүй);
- 4.9.9. Банкнаас нэмэлтээр олгож буй бусад үйлчилгээг авах.

4.10. Ти Ди Би Онлайн үйлчилгээний гүйлгээ, төлбөр тооцоо

- 4.10.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хоёр өөр төрлийн валютын дансны хооронд хийгдэх гүйлгээг тухайн үеийн Банкнаас зарласан валютын ханшаар тооцно.
- 4.10.2. Тухайн дансаарх гүйлгээ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, үүнтэй холбоотой хууль тогтоомжийн акт болон Банкны бодлого, журмын дагуу эрсдэлтэй буюу сэжигтэй гүйлгээнд тооцогдож байгаа, эсхүл тухайн дансанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу битүүмж тавьсан тохиолдолд гүйлгээ шилжихгүй.

4.11. ТиДиБи Онлайн үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага

- 4.11.1. Интернэт үйлчилгээ нийлүүлэгч байгууллага болон үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагч www.etdbm.mn цахим хуудсанд болон Ти Ди Би Онлайн аппликейшнд холбогдоход сүлжээний саатал, гүйлгээг хүлээн авах банкны үйл ажиллагааны доголдол, эсвэл харилцагчийн холбогдож буй компьютер, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үүссэн аливаа хохирлыг Банк хариуцахгүй.
- 4.11.2. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд холбогдоход нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байх бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг Банк хариуцахгүй.

ТАВ. МОСТ МОНИ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Мост Мони үйлчилгээний эрхээрээ Банкин дахь дансаа гар утасны дугаартайгаа холбож, гар утас болон интернэт ашиглан онлайнгаар Банкны үйлчилгээг авах боломжтой.

5.2. Харилцагч нь Мост Мони үйлчилгээг ашиглан “гүйлгээг төлбөрт хүлээж авах эрхтэй үйлчилгээний байгууллага” (цаашид “Мост Мони мерчант” гэх) -аас худалдан авалт хийх, дараа төлбөрт үйлчилгээний байгууллага (цаашид “Биллер байгууллага” гэх) болон төрийн үйлчилгээ (гаалийн төлбөр, татварын төлбөр гэх мэт)-ний нэхэмжилсэн төлбөрийг төлөх, Банкны салбар, тооцооны төв болон АТМ -аар бэлэн мөнгөний гүйлгээ хийх, бусад урьдчилсан төлбөрт үйлчилгээ борлуулагч байгууллага (цаашид “Үйлчилгээг үзүүлэгч” гэх) - аас худалдан авалт хийх, төрөл бүрийн дансны болон гүйлгээний лавлагаа авах боломжтой байна.

5.3. Харилцагчийн эрх нээлгэх гар утас болон сим карт нь Мост Мони үйлчилгээний цэс суулгах шаардлагуудыг хангасан байх шаардлагатай ба интернэт ашиглахтай холбоотой интернэт дата, интернэт үйлчилгээний зардлыг Харилцагч өөрөө бүрэн хариуцна.

5.4. Харилцагч Мостмони үйлчилгээнд өөрийн нэмэлт дугаараа бүртгүүлж, БҮЕН-ийн 5.2-д заасан үйлчилгээг авах боломжтой байна.

5.5. Банк нь МостМони үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

5.5.1. Харилцагчаас өөрийн дансанд нэмэлт дугаар бүртгүүлэх, үйлчилгээний хүчинтэй хугацаа нь дууссан, гар утас нь гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн тохиолдолд үйлчилгээний эрхээ түр хаалгуулах, эсвэл гар утасны дугаараа сольж бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

5.6. Банк нь МостМони үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

5.6.1. Автомат төлөлттэй билл төлбөрийн үйлчилгээнд бүртгэлтэй харилцагчийн төлбөрийн нэхэмжлэхийн дүнг харилцагчийн заасан данснаас үл маргах журмаар тухай бүр холбогдох шимтгэлийг тооцож суутган шилжүүлнэ. Дараа төлбөрт, давтамжит үйлчилгээ (интернэт, гар утас, суурин утас, КаТВ, СӨХ, цахилгаан, гурвалсан үйлчилгээ гэх мэт.)-г үзүүлэгч байгууллагаас нэхэмжилсэн үйлчилгээний төлбөр (цаашид “билл” гэх)-ийн дүнгээр холбогдох гүйлгээг хийх ба түүний үнэн зөв, дүн зөрүүтэй байх эсэхээс үүдсэн хариуцлагыг Банк хүлээхгүй.

5.7. Харилцагч нь МостМони үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

5.7.1. Гүйлгээ хийх явцад цэсний дарааллын дагуу хүлээн авагчийн утасны дугаар, дансны дугаар, мөнгөн дүнгийн мэдээллийг үнэн зөв оруулж, гүйлгээ хийсний дараа дансны гүйлгээний хуулгаа тогтмол шалгаж байх;

5.7.2. Биллер байгууллагаас ирүүлсэн биллийн мэдээллийг тухай бүрд нь шалгаж баталгаажуулах;

5.7.3. Гар утсандаа ашиглаж байгаа Мост Мони цэсний төрлөөсөө хамааран гүйлгээний мэдээлэл дамжуулж байгаа мессэжийн болон интернэтийн төлбөрийг хариуцах.

5.8. Харилцагч нь МостМони үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

5.8.1. Өөрийн бичгээр гаргасан хүсэлтээр үйлчилгээний эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах (Энэ тохиолдолд өмнө нь төлсөн хураамжийг Банк буцаан олгохгүй);

5.8.2. Банкны салбарт ирж өөрийн дансан дээр нэмэлт утасны дугаар нэмж бүртгүүлэх, бүртгэлтэй нэмэлт утасны дугаарыг хасуулах, өөрийн эзэмшлийн дансыг нэмж бүртгүүлэх, бүртгэлтэй дансыг хасуулах, нууц үг, пин кодыг шинээр авах, блок гаргуулах, бүртгүүлсэн утасны дугаарыг солиулах, өдрийн гүйлгээний

лимитийг өөрчлүүлэх, билл төлбөрийн үйлчилгээнд өөрийн болон бусад билл төлөгчийг бүртгүүлэх, бүртгэлтэй билл төлөгчийг хасуулах, үйлчилгээний эрх сунгуулах.

5.9. Мост Мони үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага

5.9.1. Үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагч МостМони үйлчилгээний цахим хуудсанд холбогдоход сүлжээний саатал гарсан, эсвэл харилцагчийн холбогдож буй компьютерт, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үүсэх аливаа хохирлыг Банк хариуцахгүй.

5.9.2. Автомат төлөлттэй билл төлбөрийн үйлчилгээнд бүртгэлтэй харилцагчийн данснаас нэхэмжлэхийн төлбөрийг суутгах явцад дансны үлдэгдэл хүрэлцээгүйгээс шалтгаалан төлбөр хугацаандаа төлөгдөөгүйгээс үүдэн гарах эрсдэлийг Банк хариуцахгүй.

5.9.3. Нэмэлт утасны дугаараар гүйлгээ хийхдээ гэрээ болон БҮЕН-д заасан үүргийг биелүүлээгүйгээс Банк, Харилцагч болон бусад гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Банк хариуцахгүй.

5.9.4. Харилцагчийн зөвшөөрөлтэй Мост Мони Мерчант, Биллер байгууллага болон Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас Банканд ирүүлэх цахим төлбөр тооцоо хийх хүсэлтийг Банк хүлээн авах бөгөөд Харилцагч цахим төлбөр тооцоо хийх зөвшөөрөл бүхий хүсэлтийг үнэн бодит эсэхийг тодруулах, эсхүл зөвшөөрөл бүхий төлбөр тооцоо гүйцэтгэсний төлөө Банк нь ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

ЗУРГАА. ХУРИМТЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

6.1 Харилцагч дараах хоёр төрлийн хуримтлалын үйлчилгээг авах боломжтой.

6.1.1 Тогтмол шилжүүлэг үйлчилгээ- Харилцагчийн банканд өгсөн хүсэлтийн дагуу нэг удаагийн болон банкнаас санал болгож буй давтамжаас сонгон банк доторх данс хооронд мөнгөн шилжүүлгийг урьдчилан захиалах үйлчилгээ;

6.1.2 Хялбар хуримтлал үйлчилгээ - Харилцагч банканд дахь өөрийн сонгосон депозит данснаас хадгаламжийн данс руу дараах сонголтуудын дагуу шилжүүлэг хийнэ. Үүнд:

- Өдөр бүр хуримтлуулъя- Өдрийн эцэст дансны үлдэгдлийн 1'000, 2'000, 3'000, 4'000, 5'000 төгрөгөөс дооших мянгачилсан бутархай дүнг автоматаар шилжүүлэх;
- Хариултаа хадгалъя- Картын худалдан авалт болон Ти Ди Би Онлайны Төлбөр цэсээр гүйлгээ хийх бүрт 1'000-5'000 төгрөгийн хооронд сонгосон мянгачлалаар гүйлгээний дүнг бүхэлчилж тооцон зөрүү бутархай дүнг шилжүүлэх;
- Орлого бүрээс хуримтлуулъя- Зээл олголтоос бусад төрлийн орлогын гүйлгээ хийгдэх бүрт дүнгийн 1%-10%-н хооронд сонгосон хувийн дагуу шилжүүлэх;
- Тогтмол хуримтлал-Өдөр бүр 1'000 төгрөг тогтмол шилжүүлэх

6.2 Харилцагч нь хуримтлалын үйлчилгээг ашиглан дансанд байрших боломжит үлдэгдлээс хувь зааж мөн тогтмол дүнгээр мөнгөн шилжүүлгийг урьдчилан захиалах, сонгосон мянгачлал, хувийн дагуу автоматаар хадгаламжийн дансанд шилжүүлэг хийгдэх үйлчилгээг авах боломжтой байна.

6.3 Банк нь хуримтлалын үйлчилгээтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

6.3.1 Харилцагчийн хүсэлтийн дагуу заасан өдөр, заасан дүн эсхүл дансны үлдэгдлийн хувиар харилцагчийн дансны үлдэгдэлд багтаан гүйлгээг хийх;

6.3.2 Харилцагчийн хүсэлтийн дагуу сонгосон мянгачлах дүн, хувийн дагуу гүйлгээ хийгдэх тухай бүр автоматаар шилжүүлэг хийх;

6.3.3 Харилцагчийн хүсэлтийн дагуу хуримтлалын үйлчилгээний бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин бүртгүүлэх.

6.4 Банк нь хуримтлалын үйлчилгээтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 6.4.1 Үйлчилгээ үзүүлсэний шимтгэлийг харилцагчийн гүйлгээ илгээх данснаас суутган авах;
- 6.4.2 Харилцагчийн хүсэлтийн дагуу гүйлгээг хийхээр заасан өдөр илгээх дансны үлдэгдэл гүйлгээний дүн, гүйлгээ хийх доод хязгаар болон шимтгэл авахад хүрэлцэхгүй тохиолдолд гүйлгээг хийхгүй.

6.5 Харилцагч нь хуримтлалын үйлчилгээтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 6.5.1 Банканд гаргасан хүсэлтээр гүйлгээ хийгдэх өдрийн дансны үлдэгдлийг гүйлгээ хийхэд боломжтой хэмжээнд хангах.

6.6 Харилцагч нь хуримтлалын үйлчилгээтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 6.6.1 Банканд бүртгүүлсэн хуримтлалын үйлчилгээний бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин бүртгүүлэх.

ДОЛОО. АВТОМАТ БИЛЛ ҮЙЛЧИЛГЭЭ

7.1. Харилцагч Автомат билл үйлчилгээг ашиглан өөрийн дансдаас ХХБ-ны биллинг системд нэгдсэн байгууллагуудын төлбөрийг автоматаар төлөх боломжтой байна. Банк нь харилцагчийн төлбөрийг нэхэмжлэгч байгууллагаас нэхэмжлэх ирсэн даруйд төлөх оролдлогыг хийх ба дараагийн нэхэмжлэх банканд ирэх хүртэл эсвэл нэхэмжлэх амжилттай төлөгдөх хүртэл төлбөр төлөх оролдлогыг хийнэ.

7.2. Банк нь Автомат билл үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 7.2.1. Төлбөр хүлээн авагчаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дүнг төлбөр хариуцагчийн данснаас үл маргах журмаар суутган авах;
- 7.2.2. Үйлчилгээ үзүүлсний шимтгэлийг ХШЕН-д заасны дагуу суутган авах;
- 7.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ төлбөр хариуцагчаас биелүүлэхийг шаардах, хэрэв удаа дараа зөрчсөн тохиолдолд төлбөр хариуцагчийн гэрээг дангаараа цуцлах.

7.3. Банк нь Автомат билл үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

- 7.3.1. Төлбөр хүлээн авагчаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн төлбөр хариуцагчийн данснаас төлбөрийг суутган авах;
- 7.3.2. Төлбөр хариуцагчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүйгээс шалтгаалан төлбөрийн нэхэмжлэх, нэхэмжлэхийн хүчинтэй хугацаанд төлөгдөөгүй тохиолдолд төлбөр хүлээн авагчтай байгуулсан гэрээний дагуу арга хэмжээг авах;
- 7.3.3. Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд мэдэгдэх;
- 7.3.4. Төлбөрийн нэхэмжлэхийн дагуу данснаас хасалт хийх үед гүйлгээ хийгдсэн мэдээллийг цахим шуудангаар төлбөр хариуцагчид мэдэгдэх;
- 7.3.5. Төлбөр хариуцагчаас гаргасан төлбөрийн нэхэмжлэхтэй холбоотой хүсэлт, гомдол, маргааныг шийдвэрлэхэд төлбөр хүлээн авагчтай хамтран ажиллах.

7.4. Харилцагч нь Автомат билл үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

- 7.4.1. Холбогдох дансандаа төлбөрийн хүчинтэй хугацаанд төлбөрийн нэхэмжлэхийг төлөхөд хангалттай үлдэгдэл байршуулах;
- 7.4.2. Төлбөрийн нэхэмжлэхийн дүнг төлбөр хүлээн авагчаас лавлан, тулгаж байх.

7.5. Харилцагч нь Автомат билл үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 7.5.1. Төлбөрийн нэхэмжлэхийн гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг цахим шуудангаар хүлээн авах;
- 7.5.2. Төлбөрийн нэхэмжлэхтэй холбоотой аливаа гомдол, санал, маргааныг банканд гаргах;

7.5.3. Төлбөр нэхэмжлэгч байгууллагатай байгуулсан Гэрээгээ цуцлах талаар банканд мэдэгдэх;

7.6. Автомат билл үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага:

7.6.1. Төлбөр хариуцагчийн данс дахь мөнгөн хөрөнгө хүрэлцээгүйн улмаас төлбөрийн нэхэмжлэхийн дагуу гүйлгээ хийгдээгүйгээс учирсан аливаа хохирлыг банк хариуцахгүй.

7.6.2. Төлбөр хариуцагчийн мэдээлэл нь өөрчлөгдсөн бөгөөд түүнийгээ банканд мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг банк хариуцахгүй;

7.6.3. Төлбөр хүлээн авагчийн буруугаас төлбөр хариуцагчид учирсан аливаа торгууль, хохирлыг банк хариуцахгүй;

7.6.4. Төлбөр хариуцагч нь төлбөрийн нэхэмжлэх төлөх дансны дугаар болон картын дугаар өөрчлөгдсөн үед банканд тэмдэглүүлээгүйгээс үүдэн гарах аливаа торгууль, хохирлыг банк хариуцахгүй.

НАЙМ. МЭДЭГДЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

8.1. Мэдэгдлийн үйлчилгээ гэж харилцагч банканд дахь дансны гүйлгээ, үлдэгдлийн мэдээлэл болон бусад төрлийн лавлагааг цахим шуудан болон мессежээр авах үйлчилгээг ойлгоно.

8.2. Харилцагч мэдэгдлийн үйлчилгээг үзүүлэхээр банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийг (цаашид "Оператор компани" гэх), Банкны мессежид суурилсан үйлчилгээнд ашиглагдах, оператор компаниудад банкны нэр дээр үүсгэгдсэн, банкны эзэмшлийн тусгай дугаарыг (цаашид "133133 тусгай дугаар" гэх), Харилцагчийн мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй дансыг төлөөлөх тогтмол нууц тоог (цаашид "Нууц дугаар" гэх) ашиглан үйлчилгээ авах боломжтой байна.

8.3. Банк нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

8.3.1. Үйлчилгээ үзүүлсний шимтгэлийг ХШЕН-д заасны дагуу суутган авах;

8.3.2. Харилцагч Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй утасны дугаараа бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн шинэ эзэмшигч нь уг дугаарыг мэдэгдлийн үйлчилгээнд бүртгүүлэх хүсэлт гаргасан бол банк тус утасны дугаар дээр бүртгэлтэй өмнөх мэдэгдлийн үйлчилгээний бүртгэлийг цуцалж, шинэ харилцагчийг үйлчилгээнд бүртгэнэ.

8.4. Банк нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

8.4.1. Харилцагчийн бүртгүүлсэн сувгаар үйлчилгээг цаг хугацаанд нь явуулах;

8.4.2. Үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд мэдэгдэх;

8.4.3. Харилцагчийн хүсэлтийн дагуу үйлчилгээг цуцлах.

8.5. Харилцагч нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

8.5.1. Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгүүлсэн харилцагчийн утасны дугаар, цахим шуудан хаяг өөрчлөгдсөн бол банканд мэдэгдэж, үйлчилгээний бүртгэлийн мэдээллийг шинэчлүүлэх.

8.6. Харилцагч нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

8.6.1. Мэдэгдлийн үйлчилгээний талаарх мэдээллийг бүртгүүлсэн сувгаараа хүлээн авах;

8.6.2. Үйлчилгээтэй холбоотой аливаа гомдол, саналыг банканд гаргах;

8.6.3. Гэрээгээ цуцлах талаар банканд мэдэгдэх;

8.6.4. Мэдэгдлийн үйлчилгээний бүртгэлийн мэдээллийг өөрчлүүлэх. Үүнд:

8.6.4.1. Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй утасны дугаараа солиулах;

8.6.4.2. Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй цахим хаягаа солиулах;

8.6.4.3. Банкнаас хүлээн авч буй гүйлгээний мэдээллийн төрлийг солих;

8.6.4.4. Мэдэгдлийн үйлчилгээнд ашиглагддаг нууц үгийг шинэчлэх.

8.7. Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага:

8.7.1. Үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагчийн холбогдож буй гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үйлчилгээ хүрээгүйгээс үүсэх аливаа хохирлыг Банк хариуцахгүй;

8.7.2. Харилцагчийн мэдэгдэл авах гар утасны дугаар, цахим шуудан хаяг нь өөрчлөгдсөн бөгөөд энэ талаар банканд мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг харилцагч бүрэн хариуцна.

8.7.3. Харилцагч гар утсаа унтраасан, цэнэг нь дууссанаас утас нь унтарсан, гар утас эвдэрсэн, гар утасны мессежийн тохиргоо алдагдсан, оператор компанийн сүлжээний үйлчлэх хүрээнээс гарсан, гар утасны эрх хаагдсан, гар утасны нэгж дууссан, төлбөрийн тооцооны улмаас түр хаагдсан зэрэг шалтгааны улмаас Харилцагчийн утсанд мессеж очихгүй байх, эсвэл хоцорч очсон тохиолдолд банк харилцагчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхгүй.

ЕС. БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН

9.1. Багц бүтээгдэхүүн гэж Банкнаас санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан нэг дор хөнгөлөлттэй нөхцөл, шимтгэл, хураамжтайгаар хүргэх, харилцагчийн цагийг хэмнэх зорилго бүхий үйлчилгээ (цаашид "багц" гэх)-г, багцын төрөл гэж багцалж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний шимтгэл, хураамжаар ялгаатай багц бүтээгдэхүүнийг ойлгоно.

9.2. Багц бүтээгдэхүүнийг багцын төрлөөс хамаарч доор дурдсан нөхцөл, шаардлага хангасан харилцагч авах боломжтой. Үүнд:

| Д/д | Багцын төрөл | Шаардлага, нөхцөл |
|-----|----------------|--|
| 1 | Kids багц | 7 – 12 насны харилцагч |
| 2 | Junior багц | 13 – 18 насны харилцагч |
| 3 | Цалингийн багц | ХХБ-ны дансаар цалин олгох гэрээтэй байгууллагын ажилтан |

9.3. Харилцагч зөвхөн нэг багцын төрөлтэй байх ба багцын төрлөө цуцлах, ахин шинээр бүртгүүлэх боломжтой. Банк багцын шимтгэл, хураамж, нөхцөлийг Банкны үйлчилгээний ХШЕН-д заасны дагуу харилцагчийн данснаас суутгана.

9.4. Банк багцын хураамжийг харилцагчийн бүртгүүлсэн хураамж авах үндсэн данснаас эхэлж суутгах бөгөөд хэрэв тус данс нь үлдэгдэлгүй бол бусад боломжит данснаас суутгана. Хэрэв дээрх дансууд үлдэгдэлгүй тохиолдолд хураамжийг данснаас улайлган авахгүй.

9.5. Банк багцын эхний хураамжийг багцад бүртгүүлсэн өдөр, дараагийн хураамжийг бүртгүүлсэн өдрөөс хойш жил бүр суутгах бөгөөд тухайн үед данс үлдэгдэлгүй тохиолдолд дансанд орлого орсон өдөр багцын хураамжийг суутгаж тус өдрөөс эхлэн жил бүр хураамжийг суутгана.

9.6. Багцын хураамж төлөөгүй эсхүл багц үйлчилгээг цуцалсан тохиолдолд Банкны үйлчилгээний ХШЕН-д заасан холбогдох шимтгэл, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт хүчингүй болно.

9.7. Харилцагч багц бүтээгдэхүүнтэй холбоотой бүх төрлийн үйлчилгээг салбар, тооцооны төв харгалзахгүй авна.

9.8. Банк багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

9.8.1. Шаардлага хангаж буй харилцагчийн хүсэлтийн дагуу багц бүтээгдэхүүн, багцын төрөлд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх;

9.8.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу багц бүтээгдэхүүнийг цуцлах, шинээр багц бүртгэх;

9.8.3. Харилцагчийн дансдын үлдэгдэл нь багцын хураамж татахад хүрэлцэхгүй тохиолдолд багц бүтээгдэхүүний хураамж суутгахгүй бөгөөд татагдаагүй багцын хураамжийг хуримтлуулан өр үүсгэхгүй байх.

9.9. Банк багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

9.9.1. Харилцагчийн бүртгэлтэй багцын төрлөөс хамаарч ХШЕН-д заасан багцын хураамжийг харилцагчийн данснаас суутгах;

9.9.2. Харилцагч багц бүтээгдэхүүнийг цуцлах хүсэлт өгсөн эсвэл бусад шалтгаанаар харилцагчийн бүртгэлтэй багц бүтээгдэхүүнийг цуцласан тохиолдолд багцын төрөлд хамаарах тусгай нөхцөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хүчингүй болгох.

9.10. Харилцагч багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

9.10.1. Багцад бүртгүүлэх тохиолдолд зөвхөн нэг багцын төрөлд бүртгүүлэх;

9.10.2. Банкны ХШЕН-д заасан багцын хураамжийг багцын төрлөөс хамаарч сар бүр эсхүл жил бүр өөрийн аль нэг данснаас төлөх, суутгуулах;

9.10.3. Харилцагч багц бүтээгдэхүүнээ ашиглахгүй байх, Банканд хандаж цуцлах хүсэлт өгөөгүйгээс шалтгаалж суутгагдсан багцын хураамжийг Банк харилцагчид буцаан олгохгүй ба үүнтэй холбоотой маргаан үүсгэхгүй байх.

9.11. Харилцагч багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

9.11.1. Багцын төрлийг цуцлах, шинээр багц бүртгүүлэх;

9.11.2. Багц бүтээгдэхүүний талаарх хүү, шимтгэл, хураамж, нөхцөлийн талаар мэдээлэл авах;

9.11.3. Багцын хураамжийг төлсөн тохиолдолд багцын төрөлд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж, тусгай нөхцөлийг авах."

“Бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл”-ын Хавсралт 1

Төлбөрийн дебит карт

| Картын төрөл | Худалдаалах үнэ: | | | | | Жилийн хураамж |
|---|------------------|------------|------------|--------------------------------------|--------------------------------------|----------------|
| | 1 жил | 2 жил | 3 жил | 4 жил | 5 жил | |
| Хугацаа: | | | | | | |
| Цалингийн карт (₮, Виза, Юнионпэй) | - | - | - | - | Үнэгүй | - |
| Тэтгэврийн карт (₮, Юнионпэй) | - | - | - | - | Үнэгүй | - |
| Классик карт /орлогын/* (₮, Виза, Юнионпэй) | - | 20 000 MNT | 21 000 MNT | 22 000 MNT | - | - |
| MT карт /иргэн/ (Юнионпэй) | - | 10 000 MNT | 12 000 MNT | 15 000 MNT | - | - |
| Орифлэйм карт (Юнионпэй) | - | 10 000 MNT | 12 000 MNT | 15 000 MNT | - | - |
| Минт карт (Виза) | - | 60 000 MNT | - | - | - | - |
| Эйнштейн карт (Виза, U-money чипгүй) | 7 000 MNT | 7 000 MNT | 7 000 MNT | - | - | - |
| Лэйди карт (Виза, Юнионпэй) | - | 20 000 MNT | 25 000 MNT | 30 000 MNT | - | - |
| Алтан карт (Виза, Юнионпэй) | - | 30 000 MNT | 40 000 MNT | 50 000 MNT | - | - |
| Бизнес карт /орлогын/* (Виза, Юнионпэй) | - | - | - | - | - | 20 000 MNT |
| Платинум карт (Виза, Юнионпэй) | - | - | - | - | - | 250 000 MNT |
| Виртуал карт (Виза, Юнионпэй) | Үнэгүй | 2 000 MNT | - | - | - | - |
| Эйнштейн карт (Виза, U-money чиптэй) | - | 20 000 MNT | 21 000 MNT | 22 000 MNT | - | - |
| Картнаас бэлэн мөнгө олгох, Картанд бэлэн мөнгө тушаах | | | | | | |
| ХХБ, Голомт банк, Төрийн банкны АТМ-аас бүх төрлийн картаар төгрөг авах (гүйлгээ бүрээс) | | | | 100 MNT (түүнтэй тэнцэх бусад валют) | | |
| ХХБ-ны Салбар, ТТ-өөс бүх төрлийн картаар төгрөг авах. | | | | 200 MNT | | |
| ХХБ-ны АТМ-аас бүх төрлийн картанд төгрөг бэлнээр тушаах | | | | Шимтгэлгүй | | |
| ХХБ-ны гэрээт банкуудын салбар, ТТ-өөс: | | | | | | |
| Гэрээт банкууд (Ариг банк, Үндсэний хөрөнгө оруулалтын банк, Богд банк, Тээвэр хөгжлийн банк, Кредит банк, Капитрон банк) | Салбар, ТТ | Төгрөг | | 300 MNT | | |
| | | Ам.доллар | | 0.3% (мин 0.2 USD) | | |
| | АТМ | Төгрөг | | 300 MNT | | |
| Монголбанкны үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээн дэх бусад банкуудын АТМ, салбар, ТТ-өөс | | | | | 500 MNT (түүнтэй тэнцэх бусад валют) | |

| Виза, Юнионпей Интернэшнлийн сүлжээнд гадаадын банкны | АТМ | Салбар,ТТ |
|---|--|---------------------------|
| Виза картаар | 1.5 % (мин 3 USD; 3 EUR) | 2.0 % (мин 3 USD; 3 EUR) |
| Юнионпей картаар | 0.6 % (мин 3 USD; 15 CNY) | 1.0 % (мин 3 USD; 15 CNY) |
| (Юнионпей карт нь юанаар гүйлгээ хийсэн тохиолдолд юаний шимтгэл тооцох бөгөөд бусад валютаар гүйлгээ хийсэн тохиолдолд ам.доллараар тооцно.) | | |
| Картаас шилжүүлэг, гүйлгээ хийх | | |
| АТМ ашиглан картын дугаар руу болон дансны дугаар руу шилжүүлэг хийх (гүйлгээ бүрээс) | 100 MNT (түүнтэй тэнцэх бусад валют) | |
| АТМ-аас төлбөр хийх үйлчилгээ (төлбөр бүрээс) | 100 MNT (түүнтэй тэнцэх бусад валют) | |
| Картаар үйлчлэгч байгууллагад хийх худалдан (интернет худалдан авалт) авалтын гүйлгээ | Шимтгэлгүй | |
| Төрийн үйлчилгээний төлбөр төлөх | Монголбанкны үйлчилгээний ерөнхий нөхцлийн дагуу | |

БАНКНЫ БҮТЭЭГДЭХҮҮН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ -
БАЙГУУЛЛАГА

2023.03.31

ГАРЧИГ

| | |
|--|----|
| НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ | 3 |
| ХОЁР. ХАРИЛЦАХ ДАНС..... | 3 |
| ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛБӨРИЙН ДЕБИТ КАРТ | 5 |
| ДӨРӨВ. ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 7 |
| ТАВ. ТОГТМОЛ ШИЛЖҮҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ | 11 |
| ЗУРГАА. АВТОМАТ БИЛЛ ТӨЛБӨР ҮЙЛЧИЛГЭЭ | 11 |
| ДОЛОО. МЭДЭГДЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ..... | 12 |
| НАЙМ. БАНКНЫ ДАНСААР АЖИЛТНУУДЫН ЦАЛИН ОЛГОХ | 13 |
| ЕС. ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ | 15 |
| АРАВ. БАЙГУУЛЛАГЫН БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН..... | 15 |

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Энэхүү Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл (цаашид **"БҮЕН"** гэх) нь Харилцагчийн Банктай байгуулсан Харилцагчид үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээ (цаашид **"Гэрээ"** гэх)-ний салшгүй хэсэг байна. БҮЕН-д тусгайлан тайлбарласнаас бусад нэр томъёог Гэрээнд тайлбарласан утгаар ойлгоно.

1.2. Харилцагч нь Карт, пин код, гар утас, цахим шуудан хаяг, нэвтрэх нэр, нэвтрэх болон гүйлгээний нууц үг болон бусад баталгаажуулалтын хэлбэрийг алдсан, бусдад задруулсан гэж үзэж байгаа болон нууцлалын төхөөрөмжийг гээсэн, нэвтрэх эрхийг зөвшөөрөлгүйгээр ашиглан аливаа эх үүсвэрээс хандах оролдлого хийсэн, хандсан, гүйлгээ хийх оролдлого гаргасныг мэдсэн тохиолдолд Бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран дараах боломжит сувгуудаар Банканд нэн даруй мэдэгдэж үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй. Үүнд:

| Бүтээгдэхүүний төрөл | 1900-1977, 1800-1977 дугаарт холбогдох (гадаадаас 976-70161988) | info@tdbm.mn-д банканд бүртгэлтэй өөрийн цахим хаягаас хандах | Банкны салбар, тооцооны төв дээр биечлэн ирэх | ТиДиБи Онлайн үйлчилгээгээр дамжуулах |
|----------------------|---|---|---|---------------------------------------|
| Карт | √ | √ | √ | √ |
| ТиДиБи Онлайн | √ | √ | √ | |
| Мэдэгдлийн үйлчилгээ | √ | √ | √ | |

1.3. Гүйлгээнд тавих Банкны хязгаарлалт

1.3.1. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хийгдэх гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах үүднээс Банк гүйлгээ гаргах боломжит хэмжээг бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааруулж дараах байдлаар ялгаатай тогтооно. Үүнд:

| Бүтээгдэхүүний төрөл | Нэг удаагийн гүйлгээ хийх дээд лимит | Нэг өдөрт гүйлгээ хийх дээд лимит | Бүтээгдэхүүний нууц үг, пин код оруулах оролдлогын тоо |
|-------------------------|--------------------------------------|-----------------------------------|--|
| Карт /КҮБ, Банкны нэгж/ | Картын төрлөөс хамаарна | Картын төрлөөс хамаарна | Картын төрлөөс хамаарна |
| ТиДиБи Онлайн | Багцын төрлөөс хамаарна | Багцын төрлөөс хамаарна | Багцын төрлөөс хамаарна |

1.3.2. Харилцагч Банканд хүсэлт гаргаснаар БҮЕН-ийн 1.3.1 дэх заалтад заасан карттай холбоотой хязгаарлалтыг өөрийн хүсэлтээр тогтоож болно.

ХОЁР. ХАРИЛЦАХ ДАНС

2.1. Харилцагч нь Данстай холбоотой бүх төрлийн үйлчилгээг Банкны нэгж харгалзахгүй авна.

2.2. Харилцагч дансаараа зургаан сарын турш гүйлгээ хийгээгүй тохиолдолд "түр идэвхгүй" төлөвт шилжин, Банк дансны үлдэгдэлд харгалзах хүүг тооцож, данс хөтөлсний шимтгэлийг суутган авах бөгөөд дансаар гурван жилийн турш гүйлгээ хийгдээгүй тохиолдолд "зогсоосон" төлөвт шилжин Банк дансны үлдэгдэлд хүү тооцохгүй.

2.3. Зогсоосон төлөвт байгаа дансны доод үлдэгдэл 1,000.00 /мянган төгрөг/, түүнтэй тэнцэх гадаад валютаас бага болсон тохиолдолд Банк дансыг хаана.

2.4. Харилцагчийн Банканд бүрдүүлж өгсөн баримт бичгүүд нь хууль бус, хуурамч болох нь тогтоогдсон, төлбөр тооцооны баримтыг хуурамчаар үйлдэх, худал мэдүүлэг хийх, банкиг төөрөгдүүлэх, залилан мэхлэх оролдлого хийсэн харилцагчийн үйлдэл нь нотлогдсон бол Банк Харилцах дансыг хаана.

2.6. Банк Харилцах данстай холбоотой дараах тусгай үүрэгтэй. Үүнд:

2.6.1. Түр дансны хувьд хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдүүлэх зорилгоор Харилцагчаас дансанд байршуулах мөнгөн хөрөнгийг хүлээн авч, орлогын гүйлгээг хийх;

2.6.2. Банк хоорондын өндөр дүнтэй гүйлгээ илгээх сүлжээний сүүлчийн цагаас хойш хийгдсэн гүйлгээг дараагийн ажлын өдөрт багтаан гүйцэтгэх.

2.7. Банк Харилцах данстай холбоотой дараах тусгай эрхтэй. Үүнд:

2.7.1. Харилцах дансанд гадаад валютаар шилжиж ирсэн гуйвуулгыг Банкнаас зарласан тухайн өдрийн арилжааны ханшаар хөрвүүлж гүйлгээг хийх;

2.7.2. Данс, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах зорилгоор Харилцагчаас бусад мэдээллийн талаар тодруулж нэмэлт тайлбар авч баталгаажуулах;

2.7.3. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн дагуу сэжигтэй гэж үзсэн гүйлгээг шалгах, эрх бүхий байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлэх;

2.7.4. Хууль болон гэрээнд заасан буюу Шүүх, прокурор, цагдаа, татварын байгууллага, хуульд заасан бусад эрх бүхий байгууллагын мэдэгдлийн дагуу, банкны үйлчилгээний шимтгэл, мөн зээл болон зээлтэй холбоотой бусад шимтгэл, хүүгийн төлбөрийг Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутгах.

2.7.5. Түр харилцах данс нээлгэсэн хуулийн этгээд данс нээхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж өгөөгүй бөгөөд түр харилцах данс энэхүү БҮЕН-ийн 2.2-т заасны дагуу “түр идэвхгүй” төлөвт шилжсэн тохиолдолд тухайн дансыг хаах;

2.8. Харилцагч Харилцах данстай холбоотой дараах тусгай үүрэгтэй. Үүнд:

2.8.1. Дансанд заавал байлгах үлдэгдлийг данс нээсэн тухайн өдөрт байршуулах;

2.8.2. Төлбөр тооцооны баримт болох төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, бэлэн мөнгөний зарлагын баримт, байгууллагын харилцах данснаас бэлэн мөнгө авах зарлагын баримт болон төлбөр тооцооны бусад хэрэгсэл дээр баримтыг бичсэн он, сар, өдөр, төлбөр хүлээн авагч, төлбөр хариуцагчийн дансны дугаар, нэр, үйлчлэгч банкны нэр, гүйлгээний утга, тоон болон үсгэн дүнгээр бичсэн мөнгөний дүн, харилцагчийн баталгаат гарын үсэг, тамга тэмдэг зэрэг мэдээллийг үнэн зөв мэдүүлж, банкны үйлчилгээг авах;

2.8.3. Дансыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор ашиглахгүй байх;

2.8.4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулж хийсэн гүйлгээнд тогтмол хяналт тавьж байх, үр дагаврыг хариуцах, түүнээс шалтгаалан Банк болон бусад харилцагчид учирсан хохирлыг хариуцах;

2.8.5. Итгэмжлэгдсэн төлөөлөгч шинээр бүртгэх, өөрчлөх, хасах тохиолдолд банканд бүртгэлтэй цахим шуудангаас банкны ... цахим шуудангийн хаягруу мэдээллийг явуулах;

2.8.6. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсгийн баталгааг оруулсан байдлаар дансны гарын үсгийн маягыг шинэчлэн нотариатаар баталгаажуулан ирүүлэх

2.8.7. Данснаасаа 50,000.00 ам.доллар, 50,000,000.00 төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютыг бэлнээр авах тохиолдолд ажлын 1 хоногийн өмнө банканд мэдэгдэнэ. Харилцагч нь бэлнээр авах гүйлгээний дүнг заавал өөрийн дансанд байршуулсны дараагаар банканд хандан, урьдчилан захиалга үүсгүүлэх боломжтой.

2.8.8. Түр дансны хувьд 3 сарын дотор данс нээлгэхэд шаардлагатай хуулийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр баримт бичгүүдийг Банканд бүрдүүлэн өгөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүй тохиолдолд түр дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийхгүй байх;

2.8.9. Төлбөр тооцооны баримтад баталгаат гарын үсгийн оронд дардас ашиглаж гүйлгээ хийснээс Банк болон бусад харилцагчид үүсэх хохирол, үр дагаврыг бүрэн хариуцах;

2.8.10. Байгууллагын дебит карт (цаашид “Карт” гэх)-ын дансан дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд нь захиран зарцуулах эрхээ бусдад түр хугацаагаар шилжүүлэх бол Монгол Улсын Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасан хуулийн шаардлагыг хангасан итгэмжлэл болон түр хугацаагаар эрх шилжүүлэн авч буй этгээдийн нотариатаар гэрчлүүлсэн гарын үсгийн маяг, холбогдох шийдвэр, хүсэлтийн хамт Банканд өгөх.

2.9. Харилцагч Харилцах данстай холбоотой дараах тусгай эрхтэй. Үүнд:

2.9.1. Түр данс нээлгэсэн Харилцагч нь хуулийн этгээдээ үүсгэн байгуулаагүй буюу бусад шалтгааны улмаас цаашид дансаа ашиглахгүй болсон тохиолдолд Банк түр дансны үлдэгдлийг анх түр данс нээх хүсэлт гаргаж, мөнгөн хөрөнгөө байршуулсан этгээдэд бичгээр гаргасан хүсэлтийг нь үндэслэн буцаан олгож Түр дансыг хааж болно. Харин гадаад улсаас хөрөнгө оруулалтын зориулалтаар дансанд байршсан үлдэгдлийг анх гүйлгээ хийсэн данс руу буцаан шилжүүлнэ.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ТӨЛБӨРИЙН ДЕБИТ КАРТ

3.1. Банк нь Харилцагчид Картын данс нээснээс хойш ажлын 2 өдрийн дотор Картыг хэвлэж, Харилцагчид мэдэгдэж, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл КЭ-д хүлээлгэн өгнө.

3.2. Банк нь Картаар хийгдсэн бүх төлбөр, Банканд төлөх хураамж, шимтгэл зэргийг Картын дансанд нэгтгэн бүртгэнэ.

3.3. Харилцагчийн нэр дээр олгогдсон Картаар хийгдсэн бүхий л төлбөр тооцоо, гүйлгээ нь Харилцагчид хамааралтай бөгөөд Харилцагч тэдгээрийг бүрэн хариуцна.

3.4. Карт нь олон улсын болон дотоодын төлбөр тооцооны шаардлага, стандартыг хангасан нууцлал бүхий бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо хийхэд зориулагдсан, картаар төлбөр хүлээж авах эрхтэй үйлчилгээний байгууллагуудад бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөх, АТМ (Автомат теллер машин) болон Банкны зүгээс үзүүлж буй бусад гүйлгээ хийх, нэмэлт үйлчилгээг авах боломжтой байна.

3.6. Карт нь банкны өмч байх бөгөөд байгууллагын Банканд дахь дансдтай холбогдсон төлбөрийн хэрэгсэл болно.

3.7. Банк Карттай холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

3.7.1. КЭ-д Картыг хэрхэн хэрэглэх талаар заавар, зөвлөмж өгөх;

3.7.2. Банк гэрээт банк, бусад банк болон гадаадын банкны сүлжээнд гарсан төлбөр тооцоотой холбоотой маргааныг энэхүү Гэрээ, Виза, Мастер, ЮнионПэй байгууллагуудын маргаантай гүйлгээ шалгаж шийдвэрлэх журам “Банк хоорондын төлбөрийн картын гүйлгээтэй холбоотой гомдол, маргаан шийдвэрлэх заавар”, “ХХБ-ны сэжигтэй, маргаантай, луйврын шинжтэй гүйлгээ илрүүлэх, шалгах болон шийдвэрлэх журам”, ХХБ болон Гэрээт банктай байгуулсан хамтран ажиллах гэрээ болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

3.7.3. КЭ нь КҮБ-тай харилцан зөвшилцөж, Картаар төлбөрийг нь төлсөн бараа, ажил, үйлчилгээг буцаасан бол холбогдох төлбөрийн дүнг тухайн Картын данс руу буцаан шилжүүлэх.

3.8. Банк Карттай холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 3.8.1. АТМ-д хураагдсан Картыг хураагдсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд Банкнаас ирж аваагүй бол Картыг хүчингүй болгох;
- 3.8.2. Харилцагч буюу КЭ нь захиалсан картаа 6 сарын дотор Банкнаас ирж аваагүй бол картыг хүчингүй болгох;
- 3.8.3. Харилцагч буюу КЭ-ийн буруутай үйл ажиллагааны улмаас Банк, КҮБ болон бусад гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд учирсан хохирол, зардлыг Банк нь Харилцагчийн данснаас үл маргах журмаар суутган авах эрхтэй бөгөөд хэрэв дансан дахь үлдэгдэл нь хохирлыг барагдуулж хүрэлцэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авна;
- 3.8.4. Харилцагч буюу КЭ нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон энэхүү БҮЕН-ийг зөрчсөн тохиолдолд тухайн картын гүйлгээ хийх эрхийг зогсоож, зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг КЭ болон Харилцагчаас шаардах;
- 3.8.5. Харилцагчийн дансаар луйврын шинжтэй байж болзошгүй гүйлгээ хийгдсэн тохиолдолд Харилцагчийн Банканд бүртгүүлсэн утасны дугаар, цахим шуудангийн хаягаар холбогдож гүйлгээг баталгаажуулах, холбогдож чадаагүй тохиолдолд Картыг түр хугацаанд хаах.

3.9. Харилцагч Картаар холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

- 3.9.1. КЭ нь интернет худалдан авалтад зориулсан интернет пин кодыг Банкны нэгж, АТМ болон Банкны контакт төв (1900-1977, 1800-1977, гадаадаас 976-70161988), эсхүл Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглан авна. Дотоодын картын хувьд дотоодын интернет худалдан авалтад зориулсан интернет пин код нь Картын пин кодтой ижил байх бөгөөд интернет худалдан авалт хийхдээ пин кодыг оруулаагүй хийсэн гүйлгээний аливаа эрсдэл, хохирол, зардлыг бүрэн хариуцах;
- 3.9.2. Банкнаас Картаа солиулах тухай мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд Картаа Банканд хандан солиулах, хураалгах үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 3.9.3. Гадаад, дотоодын бусад банкны сүлжээнд Картаар хийгдсэн гүйлгээнээс үүдсэн нэмэлт хүү, шимтгэл, ханшийн зөрүүг бүрэн хариуцах;
- 3.9.4. Картын дансанд уягдсан мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй бүх КЭ-ийн төлбөр, тооцоог бүрэн хариуцах, эрсдэлийг хүлээх;
- 3.9.5. КЭ нь КҮБ-ын карт уншигч төхөөрөмжид Картаа уншуулж төлбөр тооцоо гүйцэтгэхдээ КҮБ-ын ажилтанд Картаа өгч явуулахгүй байх, Картын пин код болон бусад мэдээллийг мэдэгдэхгүй байж Картыг өөрийн хараа, хяналтын доор уншуулж, хяналт тавьж байх;
- 3.9.6. Харилцагч өөрийн хүсэлтээр Картын өдөрт зарцуулах лимитийг өөрчлүүлснээс үүдэн гарах аливаа хохирол, эрсдэлийг өөрөө бүрэн хариуцах;
- 3.9.7. Харилцагч нь Картаа хаалгаснаас хойш тус Картаар өмнө нь хийсэн аливаа гүйлгээний нэхэмжлэл, авлага ирвэл Харилцагч өөрөө хариуцах;
- 3.9.8. Харилцагч нь захиалсан Картаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, эсхүл Карт захиалах үедээ бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн, хүсэлтэд заасан этгээдээр дамжуулан авч байгаа бол Картаа авсныхаа дараа Банканд бүртгэлтэй утаснаас Банкны 133133 тусгай дугаарт мессэжээр, эсхүл Банканд бүртгэлтэй цахим хаягаас info@tdbm.mn хаягт хүсэлт гарган холбогдож, идэвхжүүлнэ;
- 3.9.9. Харилцагч Картаа шуудангаар хүлээн авах хүсэлт гаргахдаа Картаа хүлээн авах хаяг болон холбогдох мэдээллийг хүсэлтэд үнэн зөв, бодитой мэдээлж бичнэ;
- 3.9.10. Харилцагч шуудангаар хүлээн авсан Картын дугуйны бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авна;
- 3.9.11. Гээсэн, үрэгдүүлсэн Картыг КЭ-ийн хүсэлтээр түр хаах ба КЭ нь Банкны Контакт төвийн утасны дугаар (19001977, 70161988, 18001977) болон Банкны нэгжүүдэд хүсэлтээ хүргүүлэх боломжтой. Нээх болон дахин захиалах тохиолдолд Байгууллагын албан тоотыг анх нээлгэсэн салбартаа хүргүүлэн захиалах боломжтой;
- 3.9.12. Харилцагч нь Картыг хаалгуулах, түр хаалгуулах, хугацаанаас нь өмнө хүчингүй болгуулах, хугацаа сунгуулах, түүнчлэн Гүйлгээнд тавих Банкны хязгаарлалтыг өөрчлүүлэх хүсэлтээ Банкны нэгжид бичгээр ирүүлнэ;

3.9.13. Тухайн КЭ-д олгогдсон Картыг бусдад дамжуулан хэрэглүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд дамжуулан хэрэглүүлснээс үүсэх хохирлыг КЭ, эсхүл Харилцагч бүрэн хариуцах;

3.9.14. Харилцагч нь КЭ-ийн картаар хийсэн төлбөр тооцоо, үйлчилгээний хураамж, шимтгэлийг Банк болон КҮБ, бусад харилцагч байгууллага, банкнуудын өмнө бүрэн хариуцна.

3.10. Харилцагч карттай холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

3.10.1. БҮЕН-ийн 3.9.12 дахь заалтад заасан хүсэлтээ албан бичгээр гаргаж, шийдвэрлүүлэх.

3.11. Карттай холбоотой Талуудын нэмэлт хариуцлага

3.11.1. Тухайн Харилцагчийн нэр дээр КЭ-д олгогдсон Картаар хийгдэж байгаа гүйлгээнд Банк хууль тогтоомж, Гэрээ болон энэхүү БҮЕН-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд хяналт тавихгүй, эрсдэлийг хариуцахгүй бөгөөд Харилцагч нь КЭ тус бүртэй тооцоо нийлэн, Картаар хийгдэх гүйлгээнд тогтмол хяналт тавина.

3.11.2. Харилцагч өөрийн Картын найдвартай байнгын ажиллагааны дагуу картын ар талд баталгаат гарын үсгийг зурж, картын хүчинтэй хугацааны дуусах хугацааг анхаарч үйлчлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд Банканд тухай бүр нь мэдэгдэж картаа шалгуулах, картын хугацааг сунгуулах, дахин хэвлүүлэх, пин кодыг шинээр авах үүрэгтэй ба шалгаагүй, Банканд мэдэгдээгүйгээс болж өөрт учирсан аливаа хохирол, маргаантай асуудлыг Харилцагч өөрөө хариуцах ба Банк хариуцахгүй.

3.11.3. Виза, ЮнионПэй картын сүлжээнд Харилцагчийн хийсэн гүйлгээ тухайн валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсэж болох ханшийн зөрүү болон Виза, ЮнионПэй интернэйшнлээс ХШЕН-өөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг Харилцагч бүрэн хариуцна.

3.11.4. Банкны сүлжээнээс гадна буюу Виза, ЮнионПэй картын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн Харилцагчийн гүйлгээнд тэдгээрээс нэмж тооцсон /тооцох/ төлбөр, хураамж, шимтгэлийг тухайн бүс нутаг, улсын банкны болоод санхүү, бизнесийн байгууллагын дотоод журам, зохицуулалтын дагуу тооцогдох тул үүнийг Банк хариуцахгүй.

3.11.5 Картын дансны валютаас өөр төрлийн валютаар төлбөр тооцоо хийсэн тохиолдолд гүйлгээний ханш нь Виза, ЮнионПэй интернэйшнл байгууллагуудын тухайн өдрийн ханш болон төлбөр тооцоог хүлээн авагч банкны арилжааны ханшаар тооцогдоно. Картын гүйлгээний дансанд тусах ханш нь нэхэмжлэгч талаас нэхэмжлэл ирүүлэн зарлага гарах өдрийн ханшаар тооцогдоно.

3.11.6 Харилцагч нь олон улсын болон дотоодын цахим худалдааны вэбсайтаас онлайнгаар бүтээгдэхүүн, үйлчилгээ авахаар бүртгүүлсэн бол тухайн төлбөр нь тогтмол давтамжтайгаар төлбөр суутгагддаг эсэх болон бусад төлбөрийн нөхцөлүүдтэй сайтар танилцан гүйлгээ хийнэ. Тухайн вэбсайтаас тогтмол үйлчилгээг авах шаардлагагүй болсон үедээ картын бүртгэлээ цуцлаагүйн улмаас үүдэх төлбөрийг харилцагч хариуцна.

3.11.7. Харилцагч шуудангаар Картаа хүргүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хүргэлтийн хугацааны дээд хязгаар 14 хоног байх бөгөөд хэрэв Харилцагч хүсэлтэд заасан хаягт тухайн хугацаанд эзгүй байх тохиолдолд шуудангийн хүргэлтийг зогсоож, Картыг Банк руу эргүүлэн татах бөгөөд Харилцагч анх карт захиалсан Банкны нэгжээс картаа ирж авна. Харилцагч шуудангаар карт хүлээн авах хаяг, холбогдох мэдээллийг алдаатай буруу мэдээлж бичсэнээс үүдэн карт хугацаандаа очоогүй, эсхүл хүсэлтэд заасан хаягт тухайн хугацаанд эзгүй байх тохиолдолд учирсан хохирол, зардлыг Банк хариуцахгүй.

ДӨРӨВ. ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Банк нь Харилцагчийн Ти Ди Би Онлайн үйлчилгээнд бүртгүүлэх нэвтрэх нэр болон холбох дансдыг Харилцагчийн хүсэлтийн дагуу бүртгэнэ.

4.2. Банк нь Ти Ди Би Онлайн үйлчилгээнд нэвтрэх Харилцагчийг таних, гүйлгээний зөвшөөрлийг батлах, Харилцагч болон Банкныг эрсдэлээс хамгаалах зорилгоор дараах нууцлалын элементүүдийг хослуулан багц бүрд ялгаатайгаар ашиглана. Үүнд:

| № | Багцын нэр | Нууцлалын элементүүд | | | | |
|---|----------------|----------------------|------------------------------------|--------------------------------|--------------------|----------------|
| | | Нэвтрэх нэр | Нэвтрэх нууц үг (олон хэрэглэгдэх) | Нэвтрэх нууц үг (нэг удаагийн) | Гүйлгээний нууц үг | Биет төхөөрөмж |
| 1 | Онлайн | √ | √ | | | |
| 2 | Онлайн плас | √ | √ | √ | | √ |
| 3 | Онлайн премиум | √ | √ | | √ | √ |

4.3. Дээрх хүснэгтэд заасны дагуу тухайн багцын Харилцагчийн хувьд түүний нууцлалын элементүүд нь Харилцагчийн Банкн дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахад хэрэглэгдэх албан ёсны баталгаат тэмдгийн дардас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн баталгаат гарын үсгийн маягийн адил хүчин төгөлдөр байна.

4.4. Харилцагч нь нууцлалын элементүүдийг ашиглан Ти Ди Би онлайн үйлчилгээгээр дамжуулан гүйлгээ хийх тохиолдолд Банк Харилцагчийн данснаас уг гүйлгээний дүнгээр хасалт хийх болохыг Талууд харилцан зөвшөөрөв.

4.5. Харилцагч 24 цагийн туршид (төлөвлөгөөт засвар үйлчилгээний цагт үйлчлэхгүй) Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглах боломжтой бөгөөд харин хэлцэлтэй арилжааны гүйлгээ нь зөвхөн ажлын өдөр, ажлын цагуудад хийгдэнэ.

4.6. Банкнаас харилцагчид худалдсан нууцлалын төхөөрөмжийн баталгаат хугацаа нь Харилцагчтай төхөөрөмж хүлээлцэх акт үйлдсэн өдрөөс хойш 1 (нэг) жил байна.

4.7. Ти Ди Би онлайн үйлчилгээний багцаас хамаарч нэг өдөрт хийх гүйлгээний дүнгийн дээд хэмжээ ялгаатай байна.

4.8. Банк нь Ти Ди Би онлайн үйлчилгээгээр дамжуулан хийж буй гүйлгээнд төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, заавар журмыг дагаж мөрдөнө.

4.9. Тухайн дансаарх гүйлгээ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, үүнтэй холбоотой хууль тогтоомжийн акт болон Банкны бодлого, журмын дагуу эрсдэлтэй буюу сэжигтэй гүйлгээнд тооцогдож байгаа, эсхүл тухайн дансанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу болон Банкн дахь зээл, зээлийн хүүгийн дүнгээр битүүмж тавьсан тохиолдолд гүйлгээ шилжихгүй.

4.10. Банк Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

4.10.1. Амжилттай хийгдсэн гүйлгээ бүрийг баталгаажуулж, гүйлгээний баримтыг Харилцагчийн Банкнд бүртгэлтэй цахим шуудан хаягт илгээх;

4.10.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу ханш тохирсон тохиолдолд арилжааны хэлцэл хийх;

4.10.3. Харилцагчийн Ти Ди Би Онлайн үйлчилгээний шимтгэлийг ХШЕН-д заасны дагуу Харилцагчийн данснаас суутгах.

4.11. Банк Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлнэ. Үүнд:

4.11.1. Аливаа маргаантай гүйлгээг шийдвэрлэхийн тулд Харилцагчийн дансанд маргаантай гүйлгээний дүнгээр хаалт тавих, битүүмжлэх;

- 4.11.2. Аливаа маргаантай гүйлгээнд Харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас үл маргах журмаар суутган авах;
- 4.11.3. Харилцагч интернет банкны үйлчилгээг Ти Ди Би онлайн үйлчилгээний цахим хуудсаар хандаж ашиглаж байгаа тохиолдолд 10 минут, аппликейшн буюу смарт сувгаар хандаж ашиглах явцад 5 минутын дотор функцийг үйлдэл хийгээгүй тохиолдолд Харилцагч болон Банкныг эрсдэлээс хамгаалах зорилгоор тухайн программаас автоматаар гаргах;
- 4.11.4 Харилцагчийн хүсэлтээр хадгаламжийн данс нээж, Харилцагч Банкны нэгжид биечлэн ирж гэрээ байгуулсны үндсэн дээр зарлагын гүйлгээ гаргах эрхийг нээх;
- 4.11.5. Харилцагч болон Банкныг эрсдэлээс хамгаалан нууц үгийн аль нэгийг нь 5 удаа буруу оруулсан тохиолдолд нууц үгийг системээс автоматаар блоклох;
- 4.11.6. Банкны эрсдэлээс сэргийлэх бодлогын дагуу болон бусад олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргийн дагуу сэжигтэй гүйлгээг зогсоох;
- 4.11.7. Эрсдэлээс сэргийлэх олон улсын болон дотоодын зохицуулагч байгууллагуудын дүрэм, журмын дагуу нууцлал, хамгаалалтын стандарт нэмж тогтоох, өөрчлөх;
- 4.11.8. Банк харилцагчийн идэвхгүй байдлыг үндэслэн 1 жилээс дээш хугацаанд идэвхгүй байсан тохиолдолд харилцагчийн Ти Ди Би Онлайн үйлчилгээний бүртгэл болон эрхийн бүлгийн төлөвийг өөрчлөх;
- 4.11.9. Тухайн ажлын өдрийн тасалбар болгох хугацаанд оруулсан гүйлгээ нь тухайн ажлын өдөрт хийгдсэнд тооцох бөгөөд бусад хугацаанд хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөрт хийгдэнэ. Энэ хугацаанд хүлээлгэд байна.

| Д/д | Гүйлгээний төрөл | Тасалбар болгох хугацаа (Улаанбаатар хотын цагаар) |
|-----|---|---|
| 1 | Өөрийн данс хооронд | Тухайн өдрийн банкны тасалбар болгох хугацаанаас дараа өдрийн тасалбар болгох хугацаа хүртэл* |
| 2 | Банк доторх | |
| 3 | Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан "Бага дүнтэй гүйлгээ" | |
| 4 | Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан "Их дүнтэй гүйлгээ" | Ажлын өдрийн 09:00 – 16:00 хооронд |

*Банкны тасалбар болгох хугацаа нь 00:00 цагаас 04.00 цагийн хооронд байна.

4.11.10. Тухайн шилжүүлэх дансны цахим төлбөрийн даалгаврын өгөгдлийг бүрэн шивсэн, данс дахь үлдэгдэл нь тухайн дүн болон холбогдох шимтгэлийг төлөхөд хүрэлцэж байгаа тохиолдолд гүйлгээ хийгдэнэ.

4.11.11 Захиалгат шилжүүлгийн гүйлгээ болон хэлцэлтэй арилжааны гүйлгээ хийх өдөр нь ажлын бус өдөр таарвал дараагийн ажлын өдөрт хийгдэнэ.

4.11.12. Бэлэн бус ханшаар хийгдсэн гүйлгээг Харилцагчийн хүсэлтээр буцаах тохиолдолд тухайн үеийн Банкны зарласан бэлэн бус ханшаар хийнэ. Түүнчлэн тус гүйлгээтэй холбоотой Харилцагчид ханшийн алдагдал үүссэн тохиолдолд Банк хариуцахгүй.

4.11.13. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хоёр өөр төрлийн валютын дансны хооронд хийгдэх гүйлгээг тухайн үеийн Банкнаас зарласан валютын бэлэн бус ханшаар тооцно;

4.11.14. Интернет үйлчилгээ нийлүүлэгч байгууллага болон үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон Харилцагч Ти Ди Би онлайн үйлчилгээний цахим хуудсанд холбогдоход сүлжээний саатал, гүйлгээг хүлээн авах банкны үйл ажиллагааны доголдол, эсхүл Харилцагчийн холбогдож буй

компьютер, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн Харилцагчид үүссэн аливаа хохирлыг Банк хариуцахгүй.

4.12. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

- 4.12.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан Банканд илгээх хүсэлтийг үнэн зөв бөглөж өгөх;
- 4.12.2. Ти Ди Би онлайн үйлчилгээнд шинээр бүртгүүлэхэд Банкнаас шинээр илгээсэн болон үйлчилгээ авах явцдаа Банканд хүсэлт гарган шинэчлүүлсэн нэвтрэх нэр болон гүйлгээний нууц үгсээ үйлчилгээнд эхний нэвтрэлтээр тэдгээрийг заавал сольж ашиглах;
- 4.12.3. Банк харилцагчийн нэвтрэх нэр, нууц үгсийн талаарх мэдээллийг Харилцагчаас авахаар шаардахгүй тул Банктай ижил нэр, цахим хаягаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх үүрэгтэй ба үүнээс үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцах. Ийм хүсэлт ирсэн тохиолдолд Банканд нэн даруй 1900-1977, 1800-1977 дугаарт холбогдох (гадаадаас 976-70161988) болон info@tdbm.mn цахим шуудангаар мэдэгдэх;
- 4.12.4. Нэвтрэх болон гүйлгээний нууц үгээ хамгийн багадаа зургаан сар тутам сольж хэвших;
- 4.12.5. Гуравдагч этгээдэд Ти Ди Би Онлайн үйлчилгээнд нэвтрэн дансаа захиран зарцуулах эрхийг шилжүүлэх шаардлага үүссэн тохиолдолд Банканд хандаж, албан ёсны итгэмжлэлээр шилжүүлэх;
- 4.12.6. Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглаж дууссан даруйдаа программаас бүрэн гарч байх, энэ үүргийг биелүүлээгүйгээс үүдэн гарах хохирлыг Харилцагч хариуцах;
- 4.12.7. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд ашиглаж буй компьютерийн болон гар утасны интернетийн төлбөрийг хариуцах;
- 4.12.8. Нууцлалын төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах;
- 4.12.9. Нууцлалын төхөөрөмжийг гээсэн, алдсан тохиолдолд Банканд нэн даруй мэдэгдэж, тухайн төхөөрөмжийг идэвхгүй төлөвт шилжүүлүүлэх;
- 4.12.10. Нууцлалын төхөөрөмж нь Харилцагчийн буруутай үйлдлээс үүдэн ажиллагаагүй болсон тохиолдолд хохирлыг Харилцагч хариуцна;
- 4.12.11. Ти Ди Би онлайн үйлчилгээнд нэмэлт хэрэглэгч бүртгүүлэх, эрхийг нь цуцлуулах, өөрчлөх, хязгаарлах тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр албан бичгээр Банканд мэдэгдэх ба мэдэгдээгүйгээс үүсэх аливаа эрсдэлийг Харилцагч өөрөө хүлээнэ;
- 4.12.12. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд холбогдоход нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашигласнаас үүдэн гарах хохирлыг Банк хариуцахгүй.
- 4.12.13. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр гүйлгээ хийхдээ гүйлгээний мэдээллийг үнэн зөв оруулан, нягталж шалгасны үндсэн дээр уг гүйлгээг хийх;
- 4.12.14. Гэрээнд хэрхэн зааснаас үл хамааран Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан Харилцагч өөрийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нууц үгийг ашиглан Банкнаас санал болгож буй БҮЕН-д нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний төслийг хүлээн зөвшөөрсөн үйлдэл хийснээр тухайн БҮЕН-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээг бичгээр байгуулж, гарын үсэг зурсантай ижил хүчин төгөлдөрт тооцно.

4.13. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээний багцаас хамаарч дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 4.13.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан өөрийн данс хооронд, банк дотроо, банк хооронд, гадаад шилжүүлэг, багц гүйлгээ, тогтмол шилжүүлгийн гүйлгээ, цалингийн багц гүйлгээ, арилжааны хэлцэл зэрэг бэлэн бус гүйлгээ хийх;
- 4.13.2. Бичгээр гаргасан хүсэлтээр үйлчилгээний эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах (Энэ тохиолдолд өмнө нь төлсөн хураамжийг Банк буцаан олгохгүй);
- 4.13.3. Өөрийн хийсэн гүйлгээний лавлагааг авах;
- 4.13.4. Банкнаас нэмэлтээр олгож буй бусад үйлчилгээг авах;
- 4.13.5. Данс, карт болон Банкны бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны цахим сувгуудыг ашиглан захиран зарцуулах, тохиргоо, мэдээллийг бичгээр гаргасан хүсэлтийн дагуу эсхүл цахим сувгуудаар дамжуулан өөрчлүүлэх, шинээр авах, эрхээ сэргээлгэх болон хаалгах.

ТАВ. ТОГТМОЛ ШИЛЖҮҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Харилцагч Банканд хүсэлт гарган, Тогтмол шилжүүлэг үйлчилгээнд бүртгүүлснээр өөрийн товлосон хугацаа (өдөр, сар, улирал)-нд, өөрийн дансанд байрших боломжит үлдэгдлээс тогтмол дүнгээр, эсхүл тодорхой хувиар тооцон данс хооронд автоматаар хийгдэх мөнгөн шилжүүлгийн үйлчилгээг урьдчилан захиалах боломжтой.

5.2. Ийнхүү Харилцагчийн хүсэлтийг үндэслэн гүйцэтгэх Тогтмол шилжүүлэг бүрийг Харилцагчийн өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр буюу түүний даалгавраар гүйцэтгэсэн гэж үзэх бөгөөд Банк Тогтмол шилжүүлэг гүйцэтгэх бүрдээ Харилцагчаас дахин зөвшөөрөл авах шаардлагагүй болно.

5.3. Банк нь Тогтмол шилжүүлэг үйлчилгээтэй холбоотой дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

5.3.1. Харилцагчийн хүсэлтийн дагуу заасан өдөр, заасан дүн, эсхүл дансны үлдэгдлийн хувиар Харилцагчийн дансны үлдэгдэлд багтаан гүйлгээг хийх үүрэгтэй;

5.3.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу Тогтмол шилжүүлэг үйлчилгээний бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин бүртгэх үүрэгтэй;

5.3.3. Үйлчилгээ үзүүлсний шимтгэлийг Харилцагчийн гүйлгээ илгээх данснаас суутган авах эрхтэй;

5.3.4. Харилцагчийн хүсэлтийн дагуу гүйлгээг хийхээр заасан өдөр илгээх дансны үлдэгдэл гүйлгээний дүн, гүйлгээ хийх доод хязгаар болон шимтгэл авахад хүрэлцэхгүй тохиолдолд гүйлгээг хийхгүй байх.

5.4. Харилцагч нь Тогтмол шилжүүлэг үйлчилгээтэй холбоотой дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

5.4.1. Банканд гаргасан хүсэлтээр гүйлгээ хийгдэх өдрийн дансны үлдэгдлийг гүйлгээ хийхэд боломжтой хэмжээнд хангах үүрэгтэй;

5.4.2. Банканд бүртгүүлсэн тогтмол шилжүүлгийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин бүртгүүлэх эрхтэй.

ЗУРГАА. АВТОМАТ БИЛЛ ТӨЛБӨР ҮЙЛЧИЛГЭЭ

6.1. Харилцагч Автомат билл төлбөр үйлчилгээг ашиглан өөрийн дансдаас Банкны биллинг системд нэгдсэн байгууллагуудын төлбөрийг автоматаар төлөх боломжтой байна. Банк нь Харилцагчийн төлбөрийг нэхэмжлэгч байгууллагаас нэхэмжлэх ирсэн даруйд төлөх оролдлогыг хийх ба дараагийн нэхэмжлэх Банканд ирэх хүртэл, эсхүл нэхэмжлэх амжилттай төлөгдөх хүртэл төлбөр төлөх оролдлогыг хийнэ. Төлбөр хариуцагч нь ХШЕН-тэй танилцаж, данснаас төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлбөр суутгахыг зөвшөөрсөн бөгөөд энэ нь Гэрээг байгуулах урьдчилсан нөхцөл болохыг Талууд харилцан тохиролцов.

6.2. Банк нь Автомат билл төлбөр үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

6.2.1. Төлбөр хүлээн авагчаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дүнг төлбөр хариуцагчийн данснаас үл маргах журмаар суутган авах эрхтэй;

6.2.2. Үйлчилгээ үзүүлсний шимтгэлийг ХШЕН-д заасны дагуу суутган авах эрхтэй.

6.2.3. Төлбөр хариуцагчаас гаргасан төлбөрийн нэхэмжлэхтэй холбоотой хүсэлт, гомдол, маргааныг шийдвэрлэхэд төлбөр хүлээн авагчтай хамтран ажиллах үүрэгтэй.

6.3. Харилцагч нь Автомат билл төлбөр үйлчилгээтэй холбоотой дараах тусгай үүрэг хүлээнэ. Үүнд:

- 6.3.1. Холбогдох дансандаа төлбөрийн хүчинтэй хугацаанд төлбөрийн нэхэмжлэхийг төлөхөд хангалттай үлдэгдэл байршуулах үүрэгтэй;
- 6.3.2. Төлбөрийн нэхэмжлэхийн гүйлгээ хийгдсэн талаарх мэдээллийг Банканд бүртгэлтэй цахим шуудан хаягаар хүлээн авах эрхтэй.
- 6.3.3. Автомат билл төлбөр төлөх дансны дугаараа өөрчлөх эрхтэй.

6.4. Талууд Автомат билл төлбөр үйлчилгээтэй холбоотой дараах нэмэлт хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

- 6.4.1. Төлбөр хариуцагчийн дансан дахь мөнгөн хөрөнгө хүрэлцээгүйн улмаас төлбөрийн нэхэмжлэхийн дагуу гүйлгээ хийгдээгүйгээс учирсан аливаа хохирлыг Банк хариуцахгүй.
- 6.4.2. Төлбөр хариуцагчийн мэдээлэл нь өөрчлөгдсөн бөгөөд ийнхүү өөрчлөгдсөн талаар Банканд мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг Банк хариуцахгүй.
- 6.4.3. Төлбөр хүлээн авагчийн буруугаас төлбөр хариуцагчид учирсан аливаа торгууль, хохирлыг Банк хариуцахгүй.
- 6.4.4. Төлбөр хариуцагч нь төлбөрийн нэхэмжлэх төлөх дансны дугаар өөрчлөгдсөн үед Банканд тэмдэглүүлээгүйгээс үүдэн гарах аливаа торгууль, хохирлыг Банк хариуцахгүй.

ДОЛОО. МЭДЭГДЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

7.1. Харилцагч нь мэдэгдлийн үйлчилгээг үзүүлэхээр Банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдийг (цаашид **"Оператор компани"** гэх) Банкны мессежид суурилсан үйлчилгээнд ашиглагдах, оператор компаниудад Банкны нэр дээр үүсгэгдсэн, банкны эзэмшлийн тусгай дугаарыг (цаашид **"133133 тусгай дугаар"** гэх) Харилцагчийн мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй дансыг төлөөлөх тогтмол нууц тоо (цаашид **"Нууц дугаар"** гэх)-г ашиглан энэхүү үйлчилгээг авах боломжтой.

7.2. Банк нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

- 7.2.1. Харилцагч Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй утасны дугаараа бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн шинэ эзэмшигч нь уг дугаарыг мэдэгдлийн үйлчилгээнд бүртгүүлэх хүсэлт гаргасан бол Банк тус утасны дугаар дээр бүртгэлтэй өмнөх мэдэгдлийн үйлчилгээний бүртгэлийг цуцалж, шинэ харилцагчийг үйлчилгээнд бүртгэнэ.
- 7.2.2. Харилцагчийн бүртгүүлсэн сувгаар үйлчилгээг цаг хугацаанд нь явуулах үүрэгтэй.

7.3. Харилцагч нь Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх эдэлнэ. Үүнд:

- 7.3.1. Мэдэгдлийн үйлчилгээний талаарх мэдээллийг бүртгүүлсэн сувгаараа хүлээн авах;
- 7.3.2. Мэдэгдлийн үйлчилгээний бүртгэлийн мэдээллийг өөрчлүүлэх. Үүнд:
 - 7.3.2.a. Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй утасны дугаараа солиулах;
 - 7.3.2.b. Мэдэгдлийн үйлчилгээнд бүртгэлтэй цахим шуудан хаягаа солиулах;
 - 7.3.2.c. Банкнаас хүлээн авч буй гүйлгээний мэдээллийн төрлийг солих;
 - 7.3.2.d. Мэдэгдлийн үйлчилгээнд ашиглагддаг нууц дугаар шинэчлэх.

7.4. Мэдэгдлийн үйлчилгээтэй холбоотой нэмэлт хариуцлага:

- 7.4.1. Үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон Харилцагчийн холбогдож буй гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн Харилцагчид үйлчилгээ хүрээгүйгээс үүсэх аливаа хохирлыг Банк хариуцахгүй;
- 7.4.2. Харилцагчийн мэдэгдэл авах гар утасны дугаар, цахим шуудан хаяг нь өөрчлөгдсөн бөгөөд энэ талаар Банканд мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг Харилцагч бүрэн хариуцна;

7.4.3. Харилцагч гар утсаа унтраасан, цэнэг нь дууссанаас утас нь унтарсан, гар утас нь эвдэрсэн, гар утасны мессежийн тохиргоо алдагдсан, Оператор компанийн сүлжээний үйлчлэх хүрээнээс гарсан, гар утасны эрх хаагдсан, гар утасны нэгж дууссан, төлбөр тооцооны улмаас түр хаагдсан зэрэг шалтгааны улмаас Харилцагчийн утсанд мэдэгдэл очихгүй байх, эсхүл хоцорч очсон тохиолдолд Банк Харилцагчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхгүй.

НАЙМ. БАНКНЫ ДАНСААР АЖИЛТНУУДЫН ЦАЛИН ОЛГОХ

8.1. Банкны дансаар ажилтнуудын цалин олгох үйлчилгээгээр Харилцагчийн ажилтан, албан хаагчид (цаашид **"Ажилтан"** гэх)-ын цалин, урамшуулал болон түүнтэй адилтгах бусад орлогыг Банкны цалингийн (харилцах, хадгаламж) дансаар дамжуулан олгох үйлчилгээг үзүүлнэ.

8.2. Банк Харилцагчийн нэр дээр цалин олгох данс нээх ба Харилцагч Банканд дахь өөрийн цалин олгох данс руу нэг удаа олгох цалингийн нийт дүнг тухай бүр шилжүүлнэ.

8.3. Харилцагч нь Банкны нэгжид хандах, эсхүл Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан цалингийн гүйлгээг хийж болно.

8.4. Харилцагч нь Банкны нэгжид хандан цалингийн гүйлгээ хийж буй тохиолдолд ажилтны нэрс, цалингийн дансны дугаар, цалингийн дүн бүхий жагсаалт (цаашид **"Жагсаалт"** гэх)-ыг бэлтгэж, Банкны нэгжийн цахим хаягт Excel файлаар болон эх хувиар ирүүлнэ.

8.5. Банканд цалин шилжүүлсэн төлбөрийн даалгавар, жагсаалт дээр Харилцагч гарын үсэг, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

8.6. Цалин олгох дансанд ажилтнуудад олгох нийт цалин орсон дүн болон жагсаалтаар олгох цалингийн нийт дүн хоорондоо тохирсон тохиолдолд Банк нь Жагсаалтыг хүлээн авснаас хойш ажлын нэг хоногийн дотор цалинг Ажилтан тус бүрийн цалингийн дансанд гүйлгээ хийнэ.

8.7. Цалин олгох дансны үлдэгдэл болон байгууллагаас ирүүлсэн цалин олгох жагсаалтын дүн хоорондоо зөрсөн буюу цалин олгох дансанд үлдэгдэл үлдсэн тохиолдолд уг үлдэгдлийг үндсэн харилцах данс руу өдрийн эцэст шилжүүлэх зорилгоор **"Төвлөрүүлэх шилжүүлэг"** үйлчилгээг цалин олгох дансанд бүртгэнэ.

8.8. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан цалингийн гүйлгээ хийх тохиолдолд тусгай загварын дагуу Excel файлыг хавсаргаснаар цалингийн гүйлгээг хийнэ.

8.9. Харилцагч ямар нэг байдлаар ажилтнуудынхаа цалинг Банкны дансаар олгохооргүй болсон тохиолдолд Банкнаас цалингийн зээл авсан ажилтны зээлийн төлбөрийг барагдуулж дуусах хүртэл хугацаанд тухайн ажилтны цалинг Банкны цалингийн дансанд шилжүүлэх үүрэгтэй.

8.10. Харилцагчийн нягтлан бодогч Ажилтны цалингийн картыг Банкнаас хүлээн авснаас хойш КЭ-д тараах хүртэлх хугацаанд гарсан аливаа эрсдэлийг Харилцагч бүрэн хариуцна.

8.11. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан тохиолдолд Ажилтны цалингийн зээл, зээлийн эрх, зээлийн эргэн төлөлтийн хугацаа дуусгавар болтол Харилцагч Банканд дахь цалингийн дансаар цалинг нь дамжуулах үүрэгтэй.

8.12. Харилцагч нь ажилтнуудынхаа цалинг Банкны дансаар дамжуулан олгохгүй 6 сар өнгөрсөн бөгөөд энэ үед Харилцагчийн ажилтнууд Банканд зээл, зээлийн хүү, бусад аливаа өр төлбөргүй, Талууд харилцан хүлээх аливаа төлбөр тооцооны үүрэггүй байх тохиолдолд БҮЕН-ийн энэхүү 8 дугаар зүйлийн дагуу Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага дуусгавар болгож, цалин олгох дансыг хаахыг буюу энэхүү 8 дугаар зүйлийн үйлчлэлийг дуусгавар болгохыг Талууд үүгээр харилцан тохиролцов.

8.13. Банк дансаар цалин олгох үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх, үүрэг хүлээнэ. Үүнд:

8.13.1. Харилцагчаас гаргаж өгсөн Жагсаалтыг үндэслэн ажлын 1 хоногт багтаан ажилтны дансанд цалингийн гүйлгээ хийх үүрэгтэй;

8.13.2. Харилцагчийн хүсэлтээр түүний ажилтнуудын цалингийн зээл, зээлийн эрхтэй холбоотой мэдээллийг Харилцагчийн хүсэлтэд тусгасан цахим шуудан хаягт илгээх үүрэгтэй. Энэ тохиолдолд Харилцагч нь ажилтныхаа энэхүү мэдээллийг Банкнаас гаргуулан авах эрхтэй болохоо Банкны өмнө нотолсон байна;

8.13.3. Банк нь Жагсаалтын дагуу ажилтнуудын цалинг олгосны дараа цалингийн дансанд үлдэгдэл мөнгөн хөрөнгө үлдсэн тохиолдолд Банк үлдэгдлийг Харилцагчийн үндсэн харилцах данс руу өдрийн эцэст шилжүүлнэ;

8.13.4. Харилцагч Банкнаа дахь цалин олгох дансанд мөнгө шилжүүлээгүй, эсхүл БҮЕН-ийн 8.5 дахь хэсгийг зөрчсөн тохиолдолд Банк 8.12.1 дэх заалтын дагуу хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөх бөгөөд үүнээс үүдэн гарах хариуцлагыг Харилцагч бүрэн хариуцна.

8.14. Харилцагч дансаар цалин олгох үйлчилгээтэй холбоотой дараах тусгай эрх, үүрэг хүлээнэ. Үүнд:

8.14.1. Харилцагч ажилтны цалин урамшуулал, түүнтэй адилтгах бусад орлогыг зөвхөн Банкны цалингийн дансаар дамжуулан олгох үүрэгтэй;

8.14.2. Жагсаалтад ажилтны нэр, данс, мөнгөн дүнг алдаагүй, зөв тусгасны үндсэн дээр мөнгө шилжүүлсэн баримтын хамт Банканд өгөх үүрэгтэй;

8.14.3. Харилцагч зээл хүссэн ажилтны талаарх тодорхойлолыг Банканд үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй;

8.14.4. Харилцагч дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай Банканд ажлын 5 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

8.14.4.а.Банкнаас зээл авсан ажилтан болон Харилцагчийн хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд холбогдох нотлох баримтыг;

8.14.4.б.Банкнаас зээл авсан ажилтан нь хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн магадалгааны хуулбарыг;

8.14.4.в.Банкнаас зээл авсан ажилтан нь амь насаа алдсан тохиолдолд нас барсны гэрчилгээний хуулбарыг;

8.14.4.г.Банкнаас зээл авсан ажилтан урт хугацааны чөлөө авсан, жирэмсний амралт авсан тохиолдолд холбогдох баримтыг.

8.14.5. Харилцагч нь БҮЕН-ийн 8.4 дэх хэсэгт заасан Жагсаалтыг алдаатай гаргаж өгсний улмаас тухайн ажилтны цалин авбал зохих дүнгээр ороогүйгээс үүдэн гарах хариуцлагыг Харилцагч хариуцна.

8.14.6. Харилцагч ямар нэг байдлаар ажилтнуудынхаа цалинг Банкны дансаар олгохооргүй болсон тохиолдолд Банкнаас цалингийн зээл авсан ажилтны зээлийн төлбөрийг барагдуулж дуусах хүртэл хугацаанд тухайн ажилтны цалинг Банкны цалингийн дансанд шилжүүлэх үүрэгтэй.

8.14.7. Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан тохиолдолд Ажилтны цалингийн зээл, зээлийн эрх, зээлийн эргэн төлөлтийн хугацаа дуусгавар болтол Харилцагч Банкнаа дахь цалингийн дансаар цалинг нь дамжуулах үүрэгтэй.

ЕС. ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

9.1. Банк нь Харилцагчийн хүсэлтийг үндэслэн банк доторх болон банк хооронд харилцах данс (цаашид “шилжүүлэг хийх данс” гэх)-ны үлдэгдлийг Харилцагчийн сонгосон данс (цаашид “хүлээн авах данс” гэх)-нд шилжүүлэхийг Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээ гэх бөгөөд энэхүү үйлчилгээний дагуу Банкны гүйцэтгэх бүхий л шилжүүлгийг Харилцагчийн зөвшөөрөл буюу түүний төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэхийн дагуу гүйцэтгэсэнд тооцно.

9.2. Харилцагч Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээнд бүртгүүлэхдээ шилжүүлэг хийх данс болон хүлээн авах дансны дугаарыг тодорхой тусгасан албан бичгээр хүсэлтээ гаргана.

9.3. Банк нь Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээтэй холбоотой дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. Үүнд:

9.3.1. Харилцагчийн хүсэлтийн дагуу шилжүүлэг хийх дансны үлдэгдлийг хүлээн авах данс руу Харилцагчийн заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй;

9.3.2. Харилцагчийн хүсэлтийн дагуу Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээний бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин, шаардлагатай тохиолдолд нэмэлт гэрээ байгуулах үүрэгтэй;

9.3.3. Үйлчилгээ үзүүлсний шимтгэлийг Харилцагчийн шилжүүлэг хийх данснаас суутган авах эрхтэй;

9.3.4. Харилцагчийн хүсэлтийн дагуу гүйлгээ хийхээр заасан өдөр шилжүүлэг хийх дансны үлдэгдэл нь гүйлгээний дүн, гүйлгээ хийх доод хязгаар болон шимтгэл авахад хүрэлцэхгүй тохиолдолд гүйлгээг хийхгүй.

9.4. Харилцагч нь Төвлөрүүлэх шилжүүлэг үйлчилгээтэй холбоотой дараах эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

Үүнд:

9.4.1. Банканд бүртгүүлсэн төвлөрүүлэх шилжүүлгийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг цуцлах, дахин бүртгүүлэх эрхтэй;

9.4.2. БҮЕН-ийн 9.3.4 дэх заалтад заасан үндэслэлээр Төвлөрүүлэх шилжүүлгийн гүйлгээ хийгдээгүйн улмаас үүсэх аливаа хариуцлагаас Банкныг ангид байлгах үүрэгтэй.

АРАВ. БАЙГУУЛЛАГЫН БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН

10.1. “Байгууллагын Багц бүтээгдэхүүн” гэж банкнаас санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг багц болгон, хэрэглээний түвшинд тохирсон нөхцөл бүхий төрлүүдээр санал болгож, харилцагчийн бүртгэл, тооцоонд давуу тал бий болгох, цагийг хэмнэх зорилготой үйлчилгээ (цаашид “багц” гэх)-г; юм.

10.2. “Багцын төрөл” гэж багцад хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн нөхцөл, хураамжийн дүнгээр ялгаатай багц бүтээгдэхүүн, үйлчилгээг ойлгоно. Байгууллагын багц доор дурдсан багцын төрөл, нөхцөлтэй байна. Үүнд:

| Багцад хамаарах бүтээгдэхүүн | | Багцын төрөл, нөхцөл | | | |
|------------------------------|---------------------------------|---|------------------------------|--------------------------------|--------------------------------|
| | | Классик багц | Плас багц | Премиум багц | Премиум Плас багц |
| 1 | Банк хоорондын гүйлгээ | 100 хүртэлх гүйлгээ хийх эрх | 500 хүртэлх гүйлгээ хийх эрх | 1,000 хүртэлх гүйлгээ хийх эрх | 5,000 хүртэлх гүйлгээ хийх эрх |
| 2 | Ти Ди Би Онлайн | Онлайн плас эрхийн бүлэгтэй | Онлайн плас эрхийн бүлэгтэй | Онлайн премиум эрхийн бүлэгтэй | Онлайн премиум эрхийн бүлэгтэй |
| | | | | Васко төхөөрөмж 1ш | Васко төхөөрөмж 2ш |
| | | Жилийн хураамжгүй Гүйлгээ шимтгэлгүй | | | |
| 3 | Харилцах данс хөтөлсний шимтгэл | Шимтгэлгүй | | | |

| | | |
|----------------------------------|------------------------------|----------------------------------|
| 4 | Дансны хуулга | Шимтгэлгүй |
| 5 | Дансны тодорхойлолт | Шимтгэлгүй |
| 6 | Дансны үлдэгдлийн баталгаа | Шимтгэлгүй |
| Багцын дагалдах үйлчилгээ | | |
| 1 | Corporate Gateway үйлчилгээ | Үнэгүй |
| 2 | Push service үйлчилгээ | Сарын суурь хураамж хөнгөлөлттэй |
| 3 | Deep link үйлчилгээ | Үнэгүй |
| 4 | Financial Market news | 7 хоног тутамд илгээх |
| 5 | НӨАТ баримт илгээх үйлчилгээ | Хураамжийн дүнгээр илгээх |

10.3. **“Багцын хураамж”** гэж жил бүр харилцагчийн сонгосон багцын төрлөөс хамааран харилцагчийн төлөх багц бүтээгдэхүүний хураамжийг;

10.4. Байгууллага нь зөвхөн нэг багцын төрөлтэй байна. Ингэхдээ тухайн багцыг ашиглах эрхээ хугацаанаас нь өмнө цуцлах, өөр багцын төрөл сонгож, холбогдох хураамжийг суутгаснаар дахин бүртгүүлэх боломжтой.

10.5. Багц бүтээгдэхүүн нь 1 жилийн хугацаатай байх ба багцын нэг жилийн хураамж болон бусад шимтгэлийг байгууллагын бүртгүүлсэн хураамж авах үндсэн данснаас эхэлж суутгах бөгөөд хэрэв тус данс нь үлдэгдэлгүй бол байгууллагын бусад боломжит данснаас байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр суутгана.

10.6. Багцын эхний хураамжийг багцад бүртгүүлсэн өдөр, дараагийн хураамжийг бүртгүүлсэн өдрөөс тухай бүрт суутгах бөгөөд тухайн үед байгууллагын данс үлдэгдэлгүй тохиолдолд дансанд орлого орсон өдөр багцын хураамжийг суутгаж тус өдрөөс эхлэн жил бүр хураамжийг суутгана.

10.7. Байгууллага сонгосон багцын төрөлд хамаарах багцын нөхцөл буюу 10.2 дахь хэсэгт заасан банк хоорондын гүйлгээний эрхийг хэтрүүлсэн тохиолдолд хугацааны эцэст хэтэрсэн дүнгээр байгууллагаас шимтгэлийг нөхөж төлүүлнэ.

10.8. Байгууллага багц бүтээгдэхүүний үйлчилгээг цуцалсан тохиолдолд багцад хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүр нь банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасан холбогдох шимтгэл, хураамжийн дагуу шимтгэл авагдах тул багц бүтээгдэхүүний шимтгэл, хураамж хөнгөлөлт хүчингүй болно.

10.9. Банк багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

10.9.1. Байгууллагын хүсэлтийн дагуу багц бүтээгдэхүүний сонгосон багцын төрөлд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээг байгууллага дээр бүртгэх;

10.9.2. Байгууллагын хүсэлтийн дагуу багц бүтээгдэхүүнийг цуцлах, шинээр дахин багц бүртгэх;

10.9.3. Байгууллагын дансны үлдэгдэл нь багцын хураамж татахад хүрэлцэхгүй тохиолдолд багц бүтээгдэхүүний хураамж суутгахгүй бөгөөд татагдаагүй багцын хураамжийг хуримтлуулан өр үүсгэхгүй байх;

10.10. Банк багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

10.10.1. Байгууллагын сонгосон, бүртгэлтэй багцын төрлөөс хамаарч банкны ХШЕН-д заасан багцын хураамжийг байгууллагын данснаас суутгах;

10.10.2. Байгууллага багц цуцлах хүсэлт өгсөн эсвэл бусад шалтгаанаар харилцагчийн бүртгэлтэй багц бүтээгдэхүүнийг цуцалсан тохиолдолд багцын төрөлд хамаарах тусгай нөхцөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хүчингүй болгох;

10.11. Байгууллага багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

10.11.1. Байгууллага зөвхөн сонгосон нэг багцын төрөлд бүртгүүлэх;

10.11.2. Банкны ХШЕН-д заасан багцын хураамжийг багцын төрлөөс хамаарч жил бүр өөрийн аль нэг данснаас төлөх, суутгуулах;

10.11.3. Байгууллага сонгосон багцын төрөлд хамаарах багцын нөхцөлийг хэтрүүлсэн тохиолдолд банкны ХШЕН-н дагуу зохих шимтгэлийг нөхөж төлөх;

10.11.4. Байгууллага багц бүтээгдэхүүнд бүртгүүлсэн тохиолдолд ашиглахгүй байх эсвэл банканд хандаж цуцлах хүсэлт өгөөгүйгээс шалтгаалж суутгагдсан багцын хураамжийг банк байгууллагад буцаан олгохгүй, холбоотой маргаан үүсгэхгүй байх;

10.12. Байгууллага багц бүтээгдэхүүнтэй холбоотой дараах эрх эдэлнэ. Үүнд:

10.12.1. Байгууллага тохирох багцын төрлөө сонгох, цуцлах, шинээр багц бүртгүүлэх;

10.12.2. Байгууллагын багц бүтээгдэхүүний нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаар мэдээлэл авах;

10.12.3. Багцын хураамжийг төлсөн тохиолдолд багцын төрөлд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж тусгай нөхцөлийг авах;